

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/					
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.					
Тайлагнах хугацаа		2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал			
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар		Үнэт цаас гаргагчийн нэр: <b>Монложистикс холдинг ХК</b> Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: <b>6381251</b> Үнэт цаасны код: <b>MN00MLG05696</b> Утасны дугаар: <b>7701-5454</b>			
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр		Монголын хөрөнгийн бирж			
Бизнесийн үйл ажиллагааны салбар		Тээврийн салбар			
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо		Грант торнтон аудит ХХК			
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг		395,858,822 ширхэг			
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр		Бэлтгэсэн: З.Шинэ-Од /Санхүү эрхэлсэн захирал/ Хянасан: Г.Хишигбат /Гүйцэтгэх захирал/			
1. Жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/					
	Санхүү байдлын үзүүлэлт	<b>Мянган төгрөгөөр</b>	<b>Эхний үлдэгдэл</b>	<b>Эхний үлдэгдэл (дахин тайлагнасан)</b>	<b>Эцсийн үлдэгдэл</b>
		Эргэлтийн хөрөнгийн дүн	39,467,305	39,725,144	54,577,331
		Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,371,684	2,371,684	3,031,411
		<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>41,838,989</b>	<b>42,096,828</b>	<b>57,608,742</b>

		Өр төлбөрийн нийт дүн	16,971,794	16,958,642	14,169,258
		Эздийн өмчийн дүн	24,867,195	25,138,186	43,439,484
		<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	<b>41,838,989</b>	<b>42,096,828</b>	<b>57,608,742</b>
	Орлогын тайлан	<b>Мянган төгрөгөөр</b>	<b>2022 он</b>	<b>2022 он (дахин тайлагнасан)</b>	<b>2023 он</b>
		Борлуулалтын орлого	140,122,679	136,094,718	210,360,690
		<b>Нийт ашиг</b>	<b>16,862,378</b>	<b>16,546,609</b>	<b>18,108,007</b>
		<b>Татвар төлөхийн өмнөх ашиг</b>	<b>11,349,686</b>	<b>11,033,852</b>	<b>9,585,275</b>
		Орлогын татварын зардал	1,658,525	-1,642,248	-1,222,411
		<b>Татварын дараах ашиг</b>	<b>9,691,161</b>	<b>9,391,604</b>	<b>8,362,864</b>
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	<b>Мянган төгрөгөөр</b>	<b>2022 он</b>	<b>2022 он (дахин тайлагнасан)</b>	<b>2023 он</b>
		<b>Өмч</b>	<b>106,268</b>	<b>106,268</b>	<b>118,758</b>
		<b>Халаасны хувьцаа</b>	<b>-3,001,050</b>	<b>-3,001,050</b>	<b>-</b>
		<b>Нэмж төлөгдсөн капитал</b>	<b>2233733</b>	<b>2,233,734</b>	<b>10,187,611</b>
		<b>Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц</b>	<b>-138547</b>	<b>-138,553</b>	<b>-211,818</b>
		<b>Хуримтлагдсан ашиг</b>	<b>23,722,504</b>	<b>23,937,276</b>	<b>29,190,901</b>
		<b>Нийт дүн</b>	<b>22,922,908</b>	<b>23,137,675</b>	<b>39,285,452</b>
		<b>Хяналтын эрхгүй хувь оролцоо</b>	<b>1,944,287</b>	<b>2,000,511</b>	<b>4,154,032</b>
	<b>Нийт дүн</b>	<b>24,867,195</b>	<b>25,138,186</b>	<b>43,439,484</b>	
	Мөнгөн гүйлгээний тайлан	<b>Мянган төгрөгөөр</b>	<b>2022 он</b>	<b>2022 он (дахин тайлагнасан)</b>	<b>2023 он</b>
		Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	9,382,251	9,382,251	4,480,166
		Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-1,232,023	-1,232,023	-2,390,252
		Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-492,170	-492,170	6,037,090
		Валютын ханшийн зөрүү	724,715	724,715	-203,426
		Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	8,382,773	8,382,773	7,923,578
		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,815,535	5,815,535	14,198,308
		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,198,308	14,198,308	22,121,885
1.1.	Жилийн санхүүгийн тайлангын аудитын дүгнэлт				
	- Хавсралтаар оруулав				

1.2.	Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/																							
	- байхгүй																							
2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл																							
2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	<table border="1"> <thead> <tr> <th>Харьцаанууд</th> <th>2022 он</th> <th>2022 он (дахин тайлагнасан)</th> <th>2023 он</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Нийт ашгийн хувь</td> <td>12.0%</td> <td>12.2%</td> <td>8.6%</td> </tr> <tr> <td>Цэвэр ашгийн хувь</td> <td>6.9%</td> <td>6.9%</td> <td>4.0%</td> </tr> <tr> <td>Өөрийн хөрөнгийн өгөөж</td> <td>39%</td> <td>37%</td> <td>19%</td> </tr> <tr> <td>Нэгж хувьцаанд ноогдох ашиг</td> <td>373,333</td> <td>357,885</td> <td>14.97</td> </tr> </tbody> </table>	Харьцаанууд	2022 он	2022 он (дахин тайлагнасан)	2023 он	Нийт ашгийн хувь	12.0%	12.2%	8.6%	Цэвэр ашгийн хувь	6.9%	6.9%	4.0%	Өөрийн хөрөнгийн өгөөж	39%	37%	19%	Нэгж хувьцаанд ноогдох ашиг	373,333	357,885	14.97		
Харьцаанууд	2022 он	2022 он (дахин тайлагнасан)	2023 он																					
Нийт ашгийн хувь	12.0%	12.2%	8.6%																					
Цэвэр ашгийн хувь	6.9%	6.9%	4.0%																					
Өөрийн хөрөнгийн өгөөж	39%	37%	19%																					
Нэгж хувьцаанд ноогдох ашиг	373,333	357,885	14.97																					
2.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	<table border="1"> <thead> <tr> <th>Харьцаанууд</th> <th>2022 он</th> <th>2022 он (дахин тайлагнасан)</th> <th>2023 он</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Эргэлтийн харьцаа</td> <td>1.77</td> <td>2.02</td> <td>3.26</td> </tr> <tr> <td>Түргэн хөрвөх чадварын харьцаа</td> <td>1.77</td> <td>2.01</td> <td>3.25</td> </tr> <tr> <td>Өрийн харьцаа</td> <td>0.41</td> <td>0.40</td> <td>0.25</td> </tr> </tbody> </table>	Харьцаанууд	2022 он	2022 он (дахин тайлагнасан)	2023 он	Эргэлтийн харьцаа	1.77	2.02	3.26	Түргэн хөрвөх чадварын харьцаа	1.77	2.01	3.25	Өрийн харьцаа	0.41	0.40	0.25						
Харьцаанууд	2022 он	2022 он (дахин тайлагнасан)	2023 он																					
Эргэлтийн харьцаа	1.77	2.02	3.26																					
Түргэн хөрвөх чадварын харьцаа	1.77	2.01	3.25																					
Өрийн харьцаа	0.41	0.40	0.25																					
2.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	<p>Гадаад орчны зүгээс Орос, Украины дайны нөхцөл байдал нь ачаа тээврийн маршрут, хил гаалийн хяналт болон төлбөр тооцоонд тодорхой нөлөөл үзүүлж байна.</p> <p>Энэхүү нөхцөл байдал үйлчилүүлэгч нарт тогтмол мэдээллээр хангаж, боломжит тээврийн маршрутыг санал болгон ажиллаж байна.</p> <p>Олон улсын ОХУ эсрэг авч хэрэгжүүлж буй хориг арга хэмжээнүүдийн дагуу хоригт аливаа хэлбэрээр орсон байгууллага хувь хүнтэй харьцахгүй байх дээр анхааран ажиллаж байна.</p>																						
2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Санхүүгийн тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй болно.																						
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа,	Монложистикс Групп нь - Хаан банк: Шугамын зээл 3.5 тэрбум төгрөг шинээр авч, транзит тээврийн борлуулалтын гэрээг барьцаанд тавьсан. Тайлант хугацааны эцэст шугамын зээлийн үлдэгдэлгүй.																						

	<p>баталгааны талаарх мэдээлэл;</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хаалттай зах зээлд гаргасан байсан 2 тэрбум төгрөгийн бондын эргэн төлөлт хийгдсэн.</li> <li>- ХХБанк: Шугамын зээл 2 тэрбум төгрөг шинээр нээлгэсэн. Барьцаанд нь 360 сая.төгрөгийн урт хугацаат хадгаламж болон баталгаа гаргасан. Тус шугамын зээлийг ашиглаж эхлээгүй байна.</li> <li>- ХХБанкны репо зээлийн эргэн төлөлт 200 сая.төгрөг төлсөн.</li> </ul>									
<p>3.</p>	<p>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</p>										
<p>Их хэмжээний хэлцэл:3</p> <ol style="list-style-type: none"> <li>1. ТУЗ-ийн 2023 оны 6-р сарын 26-ны өдрийн №23/ТУЗ/22-1 тоот тогтоолоор дараах их хэмжээний хэлцэл хийхийг зөвшөөрсөн: Үүнд: Худалдаа хөгжлийн банктай байгуулах “Зээлийн эрх нээх ЗЭНГ/СС230512007” дугаартай гэрээний барьцаанд 499437761 тоот хадгаламжийн дансны үлдэгдэл болох 360,000,000 (гурван зуун жаран сая) төгрөгийг барьцаалах, барьцаа хөрөнгийн гэрээнд компанийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /Г. Хишигбат/-д олгохыг зөвшөөрсөн.</li> <li>2. ТУЗ-ийн 2023 оны 7-р сарын 31-ний өдрийн №23/ТУЗ/24 тоот тогтоолоор дараах их хэмжээний хэлцэл хийхийг зөвшөөрсөн: Үүнд: Монложистикс Холдинг компанийн эзэмшиж буй бартерийн байруудыг зах зээлийн үнээр худалдан борлуулах эрхийг, худалдах, худалдан авах гэрээнд компанийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /Г. Хишигбат/-д олгохыг зөвшөөрсөн.</li> <li>3. ТУЗ-ийн 2023 оны 12-р сарын 26-ны өдрийн №23/ТУЗ/36 тоот тогтоолоор дараах их хэмжээний хэлцэл хийхийг зөвшөөрсөн: Үүнд: Эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн зорилгоор Хаан банктай “Зээлийн шугаман гэрээний нөхцөл”-ийг сунгах, зээлийн гэрээнд хамтран үүрэг гүйцэтгэгчээр оролцохыг Гүйцэтгэх захирал /Г. Хишигбат/-д зөвшөөрсөн.</li> </ol> <p>Сонирхлын зөрчилтэй хэлцэл: 18</p> <ol style="list-style-type: none"> <li>1. ТУЗ-ийн 2023 оны 3-р сарын 02-ны өдрийн №23/ТУЗ/09 тоот тогтоолоор дараах 16 сонирхлын зөрчилтэй хэлцлийг хийхийг зөвшөөрсөн: Үүнд:</li> </ol>											
<table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th style="width: 5%;">№</th> <th style="width: 35%;">Гэрээний төрөл</th> <th style="width: 60%;">Гэрээний талууд</th> </tr> </thead> <tbody> <tr> <td style="text-align: center;">1</td> <td>Батлан даалтын гэрээ</td> <td>“Монложистикс Холдинг” ХХК болон “Мандал капитал маркетс УЦК”</td> </tr> <tr> <td style="text-align: center;">2</td> <td>Зээлийн гэрээ</td> <td>“Монложистикс Холдинг” ХХК болон “Монложистикс Карго” ХХК-Э. Сэргэлэн</td> </tr> </tbody> </table>			№	Гэрээний төрөл	Гэрээний талууд	1	Батлан даалтын гэрээ	“Монложистикс Холдинг” ХХК болон “Мандал капитал маркетс УЦК”	2	Зээлийн гэрээ	“Монложистикс Холдинг” ХХК болон “Монложистикс Карго” ХХК-Э. Сэргэлэн
№	Гэрээний төрөл	Гэрээний талууд									
1	Батлан даалтын гэрээ	“Монложистикс Холдинг” ХХК болон “Мандал капитал маркетс УЦК”									
2	Зээлийн гэрээ	“Монложистикс Холдинг” ХХК болон “Монложистикс Карго” ХХК-Э. Сэргэлэн									

3	Зээлийн гэрээ	“Монложистикс Холдинг” ХХК болон “Монложистикс Транзит” ХХК-Н.Эрдэнэбилэг
4	Зээлийн гэрээ	“Монложистикс Холдинг” ХХК болон “Монложистикс Тракинг” ХХК-Н.Алтанзул
5	Зээлийн гэрээ	“Монложистикс Холдинг” ХХК болон “Монложистикс Ворлдвайд” ХХК-И. Цогбаяр
6	Зээлийн гэрээ	“Монложистикс Холдинг” ХХК болон “Монложистикс Карго” ХХК -Э. Сэргэлэн
7	Зээлийн гэрээ	“Монложистикс Холдинг” ХХК болон “Каус Аустралис” ХХК
8	Зээлийн гэрээ	“Монложистикс Холдинг” ХХК болон “Монложистикс Карго” ХХК
9	Зээлийн гэрээ	“Монложистикс Холдинг” ХХК болон “Монложистикс Карго” ХХК
10	Менежментийн гэрээ	“Монложистикс Холдинг” ХХК болон “Каус Аустралис” ХХК
11	Менежментийн гэрээ	“Монложистикс Холдинг” ХХК болон “Монложистикс Карго” ХХК
12	Менежментийн гэрээ	“Монложистикс Холдинг” ХХК болон “Монложистикс Тракинг” ХХК
13	Менежментийн гэрээ	“Монложистикс Холдинг” ХХК болон “Монложистикс Ворлдвайд” ХХК
14	Менежментийн гэрээ	“Монложистикс Холдинг” ХХК болон “Монложистикс Транзит” ХХК
15	Ачаа тээврийн даатгалын гэрээ	“Монложистикс Холдинг” ХХК болон “Мандал Даатгал”
16	Байгууллагын ерөнхий хариуцлага, тээвэр зуучлагчийн хариуцлагын даатгалын гэрээ	“Монложистикс Холдинг” ХХК болон “Мандал Даатгал”
<p>2. ТУЗ-ийн 2023 оны 9-р сарын 05-ны өдрийн №23/ТУЗ/25 тоот тогтоолоор дараах сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрсөн: Үүнд:  “Мандал Капитал Маркетс ҮЦК” ХХК-иар зуучлуулан, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд үнэт цаасны данс нээх, үнэт цаасны дансанд үнэт цаасны арилжааны захиалга өгөх, мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээ хийх, тухайн асуудлаар компанийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /Г. Хишигбат/-д олгохыг зөвшөөрсөн.</p>		
17	Үнэ цаасны данс нээх	“Монложистикс Холдинг” ХХК болон “Мандал Капитал Маркетс ҮЦК”
<p>3. ТУЗ-ийн 2023 оны 11-р сарын 29-ны өдрийн №23/ТУЗ/34 тоот тогтоолоор дараах сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрсөн: Үүнд:  Хувьцааны үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд хоёрдогч зах зээлийн арилжаанаас хувьцаа эргүүлэн худалдан авах үйл ажиллагааг Андеррайтеры үйлчилгээ үзүүлэх эрх бүхий этгээдээр дамжуулан хэрэгжүүлэх ажиллахыг Гүйцэтгэх захирал /Г. Хишигбат/-д зөвшөөрсөн.</p>		

	18	Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн гэрээ	“Монложистикс Холдинг” ХХК болон “Мандал Капитал Маркетс ҮЦК”																																															
4. Цалин урамшууллын мэдээлэл																																																		
<p>ТУЗ-ийн цалин урамшуулал: Компанийн ТУЗ-ийн цалин болон үйл ажиллагааны төсвийг 2023 оны 11-р сарын 18-ний өдөр хуралдсан ХЭХ-аас дараах байдлаар тогтоосон бөгөөд уг батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулан, нэмэлтээр шагнал, нөхөн олговор, бусад урамшуулал олгоогүй болно.</p> <table border="1" data-bbox="277 632 1138 852"> <thead> <tr> <th data-bbox="277 632 902 680">Зардлын төсөв</th> <th data-bbox="902 632 1138 680">Нийт зардал /₮/</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="277 680 902 716">Цалингийн зардал:</td> <td data-bbox="902 680 1138 716"></td> </tr> <tr> <td data-bbox="277 716 902 751">- ТУЗ-ийн дарга</td> <td data-bbox="902 716 1138 751"></td> </tr> <tr> <td data-bbox="277 751 902 787">- ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүд</td> <td data-bbox="902 751 1138 787">197,723,902 ₮</td> </tr> <tr> <td data-bbox="277 787 902 823">- ТУЗ-ийн нарийн бичгийн дарга</td> <td data-bbox="902 787 1138 823"></td> </tr> <tr> <td data-bbox="277 823 902 852">- ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитор</td> <td data-bbox="902 823 1138 852"></td> </tr> </tbody> </table> <p>Гүйцэтгэх удирдлагын цалин урамшуулал:</p> <p>ТУЗ-ийн цалин урамшууллын хороо нь 2024 оны 01 сарын 26 өдрийн № 24/ТУЗ/03 тоот тогтоолоор Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох шагнал, урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоон баталсан.</p> <table border="1" data-bbox="272 1100 1459 1640"> <thead> <tr> <th data-bbox="272 1100 326 1205">№</th> <th data-bbox="326 1100 488 1205">Үндсэн үзүүлэлт</th> <th data-bbox="488 1100 732 1205">Хэмжүүр</th> <th data-bbox="732 1100 932 1205">Зорилтот үр дүн</th> <th data-bbox="932 1100 1459 1205">Эзлэх жин</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="272 1205 326 1268">1</td> <td data-bbox="326 1205 488 1268" rowspan="3">Ашигт ажиллагаа</td> <td data-bbox="488 1205 732 1268">Төсвийн гүйцэтгэл</td> <td data-bbox="732 1205 932 1268">Санхүүгийн тайлан</td> <td data-bbox="932 1205 1459 1268">Төлөвлөгөөний хүрээнд байх</td> </tr> <tr> <td data-bbox="272 1268 326 1331">2</td> <td data-bbox="488 1268 732 1331">Цэвэр ашиг</td> <td data-bbox="732 1268 932 1331">Санхүүгийн тайлан</td> <td data-bbox="932 1268 1459 1331">Гүйцэтгэл &gt;= 100% Төлөвлөгөө</td> </tr> <tr> <td data-bbox="272 1331 326 1394">3</td> <td data-bbox="488 1331 732 1394">Авлагын түвшин</td> <td data-bbox="732 1331 932 1394">Санхүүгийн тайлан</td> <td data-bbox="932 1331 1459 1394">Хугацаа хэтэрсэн авлага &lt;= 30% нийт авлага</td> </tr> <tr> <td data-bbox="272 1394 326 1457">4</td> <td data-bbox="326 1394 488 1457" rowspan="4">Стратегийн ажлууд OGSM</td> <td data-bbox="488 1394 732 1457">Стратеги гүйцэтгэл</td> <td data-bbox="732 1394 932 1457">OGSM тайлан</td> <td data-bbox="932 1394 1459 1457">Гүйцэтгэл &gt;= 80% Төлөвлөгөө</td> </tr> <tr> <td data-bbox="272 1457 326 1520">5</td> <td data-bbox="488 1457 732 1520">Customer Satisfaction Index</td> <td data-bbox="732 1457 932 1520">Annual survey</td> <td data-bbox="932 1457 1459 1520">Above 85%</td> </tr> <tr> <td data-bbox="272 1520 326 1583">6</td> <td data-bbox="488 1520 732 1583">IR төлөвлөгөөний биелэлт</td> <td data-bbox="732 1520 932 1583">Annual report</td> <td data-bbox="932 1520 1459 1583">Above 95%</td> </tr> <tr> <td data-bbox="272 1583 326 1640">7</td> <td data-bbox="488 1583 732 1640">Employee Satisfaction Index</td> <td data-bbox="732 1583 932 1640">Annual OCS survey</td> <td data-bbox="932 1583 1459 1640">Above 80%</td> </tr> </tbody> </table>				Зардлын төсөв	Нийт зардал /₮/	Цалингийн зардал:		- ТУЗ-ийн дарга		- ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүд	197,723,902 ₮	- ТУЗ-ийн нарийн бичгийн дарга		- ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитор		№	Үндсэн үзүүлэлт	Хэмжүүр	Зорилтот үр дүн	Эзлэх жин	1	Ашигт ажиллагаа	Төсвийн гүйцэтгэл	Санхүүгийн тайлан	Төлөвлөгөөний хүрээнд байх	2	Цэвэр ашиг	Санхүүгийн тайлан	Гүйцэтгэл >= 100% Төлөвлөгөө	3	Авлагын түвшин	Санхүүгийн тайлан	Хугацаа хэтэрсэн авлага <= 30% нийт авлага	4	Стратегийн ажлууд OGSM	Стратеги гүйцэтгэл	OGSM тайлан	Гүйцэтгэл >= 80% Төлөвлөгөө	5	Customer Satisfaction Index	Annual survey	Above 85%	6	IR төлөвлөгөөний биелэлт	Annual report	Above 95%	7	Employee Satisfaction Index	Annual OCS survey	Above 80%
Зардлын төсөв	Нийт зардал /₮/																																																	
Цалингийн зардал:																																																		
- ТУЗ-ийн дарга																																																		
- ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүд	197,723,902 ₮																																																	
- ТУЗ-ийн нарийн бичгийн дарга																																																		
- ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитор																																																		
№	Үндсэн үзүүлэлт	Хэмжүүр	Зорилтот үр дүн	Эзлэх жин																																														
1	Ашигт ажиллагаа	Төсвийн гүйцэтгэл	Санхүүгийн тайлан	Төлөвлөгөөний хүрээнд байх																																														
2		Цэвэр ашиг	Санхүүгийн тайлан	Гүйцэтгэл >= 100% Төлөвлөгөө																																														
3		Авлагын түвшин	Санхүүгийн тайлан	Хугацаа хэтэрсэн авлага <= 30% нийт авлага																																														
4	Стратегийн ажлууд OGSM	Стратеги гүйцэтгэл	OGSM тайлан	Гүйцэтгэл >= 80% Төлөвлөгөө																																														
5		Customer Satisfaction Index	Annual survey	Above 85%																																														
6		IR төлөвлөгөөний биелэлт	Annual report	Above 95%																																														
7		Employee Satisfaction Index	Annual OCS survey	Above 80%																																														
5. Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл																																																		
<p>Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2023 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр зайнаас буюу цахим хэлбэрээр 86.59%-ийн ирцтэй хуралдаж дараах шийдвэрүүдийг гаргасан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Монложистикс Холдинг ХК-ийн дүрмийн шинэчилсэн төслийг батлав.</li> </ol>																																																		

	<p>2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг 4 жилийн хугацаатайгаар кумулятив аргаар сонгов.</p> <p>3. Компанийн 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэлх хугацааны Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны төсвийг батлав.</p> <p>4. Гол ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн хүрээнд опцион гаргахыг Төлөөлөн удирдах зөвлөлд зөвшөөрөв.</p> <p>ТУЗ нь 2023 онд биечлэн, цахимаар, биечлэн болон цахим хосолсон, эчнээ санал хураалтын хэлбэрээр нийт 12 удаа, 90% ба түүнээс дээш хувийн ирцтэй хуралдаж, 39 тогтоол шийдвэр гаргасан.</p> <p>2023 онд Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо 2 удаа, Аудит, эрсдэлийн удирдлагын хороо 1 удаа, Стратеги, бизнес хөгжлийн хороо 1 удаа хуралдаж, хороодын чиг үүргийн хүрээнд хэлэлцсэн асуудлын талаар дүгнэлт, зөвлөмж гаргасан.</p> <p>Хувьцаат компани болж, компанийн дүрэм болон засаглалын бодлогын бичиг баримтуудад өөрчлөлт орох шаардлагын дагуу засаглалын дүрэм журмуудыг Компанийн засаглалын кодекс, зохицуулагч байгууллагуудын дүрэм журамд нийцүүлэн шинэчлэн батлахад анхаарч ажиллалаа. Компанийн засаглалын кодексын хэрэгжилтийн өөрийн үнэлгээг анх удаа хийсэн. Компани засаглалын кодексын үнэлгээгээр 95% буюу <b>засаглал хэвийн, эрсдэлгүй</b> гэж дүгнэгдсэн бөгөөд 2024 онд засаглалын бодлогын баримт бичгүүдийг мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллахад анхаарч байна.</p>																					
6.	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл																					
	<table border="1"> <thead> <tr> <th data-bbox="261 989 516 1020">Гол эрсдэлүүд</th> <th data-bbox="516 989 1003 1020">Тулгарч болох эрсдэл</th> <th data-bbox="1003 989 1490 1020">Авч буй арга хэмжээ</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="261 1020 516 1125">Хууль эрх зүйн орчны эрсдэл</td> <td data-bbox="516 1020 1003 1125">Олон улсын дүрам журам, дотоодын хууль эрх зүйн зохицуулалт өөрчлөгдөх, түүнийг дагаж мөрдөөгүйгээс шалтгаалан үйл ажиллагааны хязгаарлалтад орох эрсдэл</td> <td data-bbox="1003 1020 1490 1125">Холбогдох хуулийн шинэчлэлтүүдийг судалж хамтран ажиллах гэрээг сайжруулж боловсронгуй болгох болон шинээр үүсэж болох бизнесийн боломж болон эрсдэлийг тодорхойлон бизнесийн богино хугацааны стратеги төлөвлөгөөнд тусган ажиллаа.</td> </tr> <tr> <td data-bbox="261 1125 516 1209">Ажиллах хүчин хомстох эрсдэл</td> <td data-bbox="516 1125 1003 1209">Ажиллах хүчний хомстол үүсэж компанийн өсөлт болон хэвийн үйл ажиллагааны процесс алдагдах эрсдэл</td> <td data-bbox="1003 1125 1490 1209">Хүний нөөцийн бодлого, инновацыг цаг үетэй уялдуулж тогтмол сайжруулах ажлыг зохион байгуулж үйл ажиллагаанд тухай бүр нэвтрүүлж, ажилчдын чиг хандлага, дуу хоолойг тогтмол сонсох дотоод талбарыг дотооддоо бий болгон ажиллаа.</td> </tr> <tr> <td data-bbox="261 1209 516 1293">Хил гаалийн хэвийн үйл ажиллагаа алдагдах</td> <td data-bbox="516 1209 1003 1293">Дэлхий нийтийг хамарсан цар тахал, дайн, улс төр эдийн засгийн хямрал, геополитикийн таарамжгүй нөхцөл байдал зэрэг нь хил гаалийн хориг саадыг бий болгож, боомтын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах эрсдэл</td> <td data-bbox="1003 1209 1490 1293">Хамтран ажиллагч түнш байгууллагуудын холбоог өргөжүүлэн, хамтарсан шинэ тээврийн маршрутыг хөгжүүлж зах зээлд нэвтрүүлэх зэрэг ажлыг зохион байгуулж ажиллаа.</td> </tr> <tr> <td data-bbox="261 1293 516 1398">Үнийн өрсөлдөөн бий болж үнэнч харилцагчийг алдах эрсдэл</td> <td data-bbox="516 1293 1003 1398">Ажиллах хүчний хомстол үүсэж компанийн өсөлт болон хэвийн үйл ажиллагааны процесс алдагдах эрсдэл</td> <td data-bbox="1003 1293 1490 1398">Харилцагчийн үйлчилгээний стандартыг сайжруулах ажлын хүрээнд компанийн дотоод процессыг сайжруулах болон харилцагчийн сэтгэл ханамжийн үнэлгээг гадны байгууллагаар хийлгүүлэн өөрсдийн үйл ажиллагааг харилцагч төвтэй болгох ажлыг эхлүүлэн ажиллаа.</td> </tr> <tr> <td data-bbox="261 1398 516 1482">Санхүүгийн хөрвөх чадвар алдагдах</td> <td data-bbox="516 1398 1003 1482">Төлбөр түргэн гүйцэтгэх зохистой түвшин алдагдах, хөрвөх чадвар алдагдах, улмаар бизнесийн үйл ажиллагаанд саатал үүсэж, ашигт ажиллагаа буурах эрсдэл</td> <td data-bbox="1003 1398 1490 1482">Компанийн богино хугацаат авлага, өглөгийг зорилтот түвшинд төлөвлөх ажлыг тасралтгүй зохион байгуулж хэмд эх үүсвэртэй зээлийн бүтээгдэхүүнийг судлан үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ашиглалаа.</td> </tr> <tr> <td data-bbox="261 1482 516 1640">Дижитал шилжилтийн эрсдэл</td> <td data-bbox="516 1482 1003 1640">Дотоод ашиглаж буй программ хангамжийн хэвийн үйл ажиллагаа доголдох, мэдээллийн аюулгүй байдал алдагдах нөхцөлд бизнесийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөх эрсдэл</td> <td data-bbox="1003 1482 1490 1640">Системийн хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс серверийг олон улсын AWS (Amazon Web Services), GSP (Google Cloud Platform) болон дотоодын Мобиком серверт тус тус тархаан байршуулж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд дотоод ажилчдад сургалтыг тогтмол зохион байгуулан эрсдэлийг бууруулан ажиллаа.</td> </tr> </tbody> </table>	Гол эрсдэлүүд	Тулгарч болох эрсдэл	Авч буй арга хэмжээ	Хууль эрх зүйн орчны эрсдэл	Олон улсын дүрам журам, дотоодын хууль эрх зүйн зохицуулалт өөрчлөгдөх, түүнийг дагаж мөрдөөгүйгээс шалтгаалан үйл ажиллагааны хязгаарлалтад орох эрсдэл	Холбогдох хуулийн шинэчлэлтүүдийг судалж хамтран ажиллах гэрээг сайжруулж боловсронгуй болгох болон шинээр үүсэж болох бизнесийн боломж болон эрсдэлийг тодорхойлон бизнесийн богино хугацааны стратеги төлөвлөгөөнд тусган ажиллаа.	Ажиллах хүчин хомстох эрсдэл	Ажиллах хүчний хомстол үүсэж компанийн өсөлт болон хэвийн үйл ажиллагааны процесс алдагдах эрсдэл	Хүний нөөцийн бодлого, инновацыг цаг үетэй уялдуулж тогтмол сайжруулах ажлыг зохион байгуулж үйл ажиллагаанд тухай бүр нэвтрүүлж, ажилчдын чиг хандлага, дуу хоолойг тогтмол сонсох дотоод талбарыг дотооддоо бий болгон ажиллаа.	Хил гаалийн хэвийн үйл ажиллагаа алдагдах	Дэлхий нийтийг хамарсан цар тахал, дайн, улс төр эдийн засгийн хямрал, геополитикийн таарамжгүй нөхцөл байдал зэрэг нь хил гаалийн хориг саадыг бий болгож, боомтын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах эрсдэл	Хамтран ажиллагч түнш байгууллагуудын холбоог өргөжүүлэн, хамтарсан шинэ тээврийн маршрутыг хөгжүүлж зах зээлд нэвтрүүлэх зэрэг ажлыг зохион байгуулж ажиллаа.	Үнийн өрсөлдөөн бий болж үнэнч харилцагчийг алдах эрсдэл	Ажиллах хүчний хомстол үүсэж компанийн өсөлт болон хэвийн үйл ажиллагааны процесс алдагдах эрсдэл	Харилцагчийн үйлчилгээний стандартыг сайжруулах ажлын хүрээнд компанийн дотоод процессыг сайжруулах болон харилцагчийн сэтгэл ханамжийн үнэлгээг гадны байгууллагаар хийлгүүлэн өөрсдийн үйл ажиллагааг харилцагч төвтэй болгох ажлыг эхлүүлэн ажиллаа.	Санхүүгийн хөрвөх чадвар алдагдах	Төлбөр түргэн гүйцэтгэх зохистой түвшин алдагдах, хөрвөх чадвар алдагдах, улмаар бизнесийн үйл ажиллагаанд саатал үүсэж, ашигт ажиллагаа буурах эрсдэл	Компанийн богино хугацаат авлага, өглөгийг зорилтот түвшинд төлөвлөх ажлыг тасралтгүй зохион байгуулж хэмд эх үүсвэртэй зээлийн бүтээгдэхүүнийг судлан үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ашиглалаа.	Дижитал шилжилтийн эрсдэл	Дотоод ашиглаж буй программ хангамжийн хэвийн үйл ажиллагаа доголдох, мэдээллийн аюулгүй байдал алдагдах нөхцөлд бизнесийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөх эрсдэл	Системийн хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс серверийг олон улсын AWS (Amazon Web Services), GSP (Google Cloud Platform) болон дотоодын Мобиком серверт тус тус тархаан байршуулж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд дотоод ажилчдад сургалтыг тогтмол зохион байгуулан эрсдэлийг бууруулан ажиллаа.
Гол эрсдэлүүд	Тулгарч болох эрсдэл	Авч буй арга хэмжээ																				
Хууль эрх зүйн орчны эрсдэл	Олон улсын дүрам журам, дотоодын хууль эрх зүйн зохицуулалт өөрчлөгдөх, түүнийг дагаж мөрдөөгүйгээс шалтгаалан үйл ажиллагааны хязгаарлалтад орох эрсдэл	Холбогдох хуулийн шинэчлэлтүүдийг судалж хамтран ажиллах гэрээг сайжруулж боловсронгуй болгох болон шинээр үүсэж болох бизнесийн боломж болон эрсдэлийг тодорхойлон бизнесийн богино хугацааны стратеги төлөвлөгөөнд тусган ажиллаа.																				
Ажиллах хүчин хомстох эрсдэл	Ажиллах хүчний хомстол үүсэж компанийн өсөлт болон хэвийн үйл ажиллагааны процесс алдагдах эрсдэл	Хүний нөөцийн бодлого, инновацыг цаг үетэй уялдуулж тогтмол сайжруулах ажлыг зохион байгуулж үйл ажиллагаанд тухай бүр нэвтрүүлж, ажилчдын чиг хандлага, дуу хоолойг тогтмол сонсох дотоод талбарыг дотооддоо бий болгон ажиллаа.																				
Хил гаалийн хэвийн үйл ажиллагаа алдагдах	Дэлхий нийтийг хамарсан цар тахал, дайн, улс төр эдийн засгийн хямрал, геополитикийн таарамжгүй нөхцөл байдал зэрэг нь хил гаалийн хориг саадыг бий болгож, боомтын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах эрсдэл	Хамтран ажиллагч түнш байгууллагуудын холбоог өргөжүүлэн, хамтарсан шинэ тээврийн маршрутыг хөгжүүлж зах зээлд нэвтрүүлэх зэрэг ажлыг зохион байгуулж ажиллаа.																				
Үнийн өрсөлдөөн бий болж үнэнч харилцагчийг алдах эрсдэл	Ажиллах хүчний хомстол үүсэж компанийн өсөлт болон хэвийн үйл ажиллагааны процесс алдагдах эрсдэл	Харилцагчийн үйлчилгээний стандартыг сайжруулах ажлын хүрээнд компанийн дотоод процессыг сайжруулах болон харилцагчийн сэтгэл ханамжийн үнэлгээг гадны байгууллагаар хийлгүүлэн өөрсдийн үйл ажиллагааг харилцагч төвтэй болгох ажлыг эхлүүлэн ажиллаа.																				
Санхүүгийн хөрвөх чадвар алдагдах	Төлбөр түргэн гүйцэтгэх зохистой түвшин алдагдах, хөрвөх чадвар алдагдах, улмаар бизнесийн үйл ажиллагаанд саатал үүсэж, ашигт ажиллагаа буурах эрсдэл	Компанийн богино хугацаат авлага, өглөгийг зорилтот түвшинд төлөвлөх ажлыг тасралтгүй зохион байгуулж хэмд эх үүсвэртэй зээлийн бүтээгдэхүүнийг судлан үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ашиглалаа.																				
Дижитал шилжилтийн эрсдэл	Дотоод ашиглаж буй программ хангамжийн хэвийн үйл ажиллагаа доголдох, мэдээллийн аюулгүй байдал алдагдах нөхцөлд бизнесийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөх эрсдэл	Системийн хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс серверийг олон улсын AWS (Amazon Web Services), GSP (Google Cloud Platform) болон дотоодын Мобиком серверт тус тус тархаан байршуулж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд дотоод ажилчдад сургалтыг тогтмол зохион байгуулан эрсдэлийг бууруулан ажиллаа.																				
7.	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/																					
	Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид:																					

	<b>Хувьцаа эзэмшигчий нэр</b>	<b>Ширхэг</b>	<b>Эзлэх хувь</b>								
	Л.Ганзоригт	110,520,000	27.92%								
	Б.Тэлэнгэд	110,520,000	27.92%								
	Г.Хишигбат	31,560,000	7.97%								
	А.Одгэрэл	31,560,000	7.97%								
	Хувьцаа эзэмшигчдийн тоо (2023-12-31 байдлаар): 1344										
8.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл										
	<p>Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө</p> <table border="1" data-bbox="272 709 1243 919"> <thead> <tr> <th data-bbox="272 709 1052 793"><b>№ Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт</b></th> <th data-bbox="1052 709 1243 793"><b>Дүн (сая.төгрөг)</b></th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="272 793 1052 835">1 Хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалт</td> <td data-bbox="1052 793 1243 835">8,062</td> </tr> <tr> <td data-bbox="272 835 1052 877">2 Эргэлтийн хөрөнгө</td> <td data-bbox="1052 835 1243 877">2,923</td> </tr> <tr> <td data-bbox="272 877 1052 919"><b>Нийт</b></td> <td data-bbox="1052 877 1243 919"><b>10,985</b></td> </tr> </tbody> </table> <p>Зарцуулалтын тайлан:</p> <ul data-bbox="321 951 1466 1087" style="list-style-type: none"> <li>- Хөдлөх бүрэлдэхүүнийг худалдан авах ажиллагаа судалгаа гэрээний шатанд явж байгаа учир зарцуулагдаагүй байна.</li> <li>- Эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор 850,000,000 /найман зуун тавин сая/ төгрөг зарцуулсан байна.</li> </ul>			<b>№ Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт</b>	<b>Дүн (сая.төгрөг)</b>	1 Хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалт	8,062	2 Эргэлтийн хөрөнгө	2,923	<b>Нийт</b>	<b>10,985</b>
<b>№ Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт</b>	<b>Дүн (сая.төгрөг)</b>										
1 Хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалт	8,062										
2 Эргэлтийн хөрөнгө	2,923										
<b>Нийт</b>	<b>10,985</b>										
9.	Ногдол ашгийн мэдээлэл										
	<ul data-bbox="321 1188 1474 1262" style="list-style-type: none"> <li>- 2023 оны 03-р дугаар сарын 02-нд Төлөөлөн удирдах зөвлөлийн №23/ТУЗ/07 тогтоолоор 3,528,055.1 төгрөгийн ногдол ашиг хуваарилсан.</li> </ul>										
10.	Үнэт цаас гаргагчаас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл										
	<p>Бид тогтвортой хөгжлийн суурь стратегиа бататгах хүрээнд нийгэм ба байгаль орчинд ээлтэй байж, компанийн засаглалыг сайжруулах төсөл хөтөлбөрүүдийг 2023 онд шинээр эхлүүлээ. Байгаль орчин, нийгэм, засаглалын хүрээнд бидний авч хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд хэдийгээр урт хугацааг туулаагүй байгаа хэдий ч, ирээдүйд нийгэм, эдийн засаг, салбарын хөгжилд томоохон нөлөө бий болгоно гэдэгт итгэл дүүрэн ажиллаж байна.</p> <p>Нийгмийн хариуцлагын хүрээнд бид Монгол улсын ирээдүй болсон залуу үед өндөр үнэ цэн өгөх төсөл хөтөлбөрийг сонгон авч хэрэгжүүлэхийг зорьдог бөгөөд нэн тэргүүнд нийгэмд сайн дураараа үйл ажиллагаа явуулж, түүгээрээ дамжуулан өөр өөрсдийн онцлог бүхий орон зайд шинэ санал санаачлага, инновацийг нэвтрүүлж байгаа залуусаас эхэлсэн юм.</p> <p><b><u>Do Good HUB</u></b></p> <p>Монложистикс Групп нь “Лантуун дохио ТББ” үүсгэн байгуулагч Ч.Ганжавхлантай хамтран залуучуудын оролцоог дэмжих, дуу хоолойг нийгэмд хүргэх, сайн дурын залуучуудыг</p>										



идэвхжүүлэх зорилготой “Do Good Hub” төвийг 2023 оны 09 сарын 08-ний өдөр албан ёсоор нээж үйл ажиллагааг эхлүүлсэн. Уг төвийг Монложистикс Групп 100% санхүүжүүлж, залуучуудын нийгэмд оролцох оролцоог илүү тодоор нөлөөлөх зорилгод бодитой хөрөнгө оруулалт хийсэн..

### **Бидний сонгон шалгаруулж, дэмжин ажиллаж буй ТББайгууллагын танилцуулга**

Манай төв нь 2023 оны 9-р сараас үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд албан ёсны сонгон шалгаруулалт явуулж, 15 байгууллагатай 1 жилийн хугацаатай хамтран ажиллах гэрээ байгуулан, олон төрөлт үйл ажиллагааг амжилттай дэмжин хэрэгжүүлж байна. Идэвхитэй үйл ажиллагаатай хамтран ажиллаж буй зарим байгууллагуудыг танилцуулахад:

- 1. Тогтвортой хөгжлийн жигүүр НҮТББ–** (иргэдийн нийгмийн оролцоо болон хөгжлийн хүрээнд төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэх зорилготой)
  - Монгол Оюун ба Шатар төслийн хүрээнд шатрын анхан, дунд шатны багш нарыг бэлдэж, шатрын спортыг олон нийтэд сурталчлах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.
- 2. Цэцээ гүн Ротаракт клуб–** (боловсрол болон эрүүл мэндийн чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлдэг)
  - 11 дэх жилдээ зохион байгуулагдаж буй хүн бүр сурах эрхтэй зорилгын хүрээнд менторшип болон тэтгэлэг хосолсон төслийг амжилттай хэрэгжүүлсэн.
  - **Монгол туургатан хэл хуурын нийгэмлэг–** (урлаг, өв соёлоо залуу үедээ өвлүүлэн үлдээх зорилготой)
  - Чингэлтэй дүүргийн сургуулийн өмнөх боловсролын 22 багшид хэл хуур хөгжмийн 6 өдрийн сургалтыг амжилттай зохион байгуулан гэрчилгээ олгосон.
  - Нүүдэлчдийн хэмнэл хэл хуур, Олон улсын хэл хуурын өдрүүдийг Монголд анх тэмдэглэх ажлыг зохион байгуулж, нийт 77 хүнд 2 өдрийн сургалтыг Дэлхийн шилдэг хэл хуурч С.С.Шишигин, Монголын ахмад хэл хуурч өв тээгч Б.Хүүхэндүү, якут урлаач хуурч Иннокентий Уран, Монгол хэл хуурын төвийн багш Б.Батням нар удирдан явуулсан.
- 3. Еннеаграм Монгол Шийдэл ТББ–** (хүний зан чанарыг оношлон, өөрийгөө танин мэдэхэд туслах сургалтуудыг зохион байгуулдаг)
  - "Нийгэмд тодоор нөлөөлье" уриалгын хүрээнд хийгдэж буй " Ээжүүдийн сэтгэлзүй" сургалтыг зохион байгуулсан. Сургалтад сонирхсон ээжүүд оролцож өөрийгөө таньж мэдэх, стрессээ тодорхойлох, тайлах мөн сэтгэлзүйн боловсрол, эрүүл мэндийн тухай эмэгтэйчүүдэд хэрэгтэй сэдвээр сургалт хөгжлийн ажлыг хийж ажилласан.

### **Менторуудын чиглүүлэх сургалтууд**

Манай төвийн удирдах зөвлөлийн гишүүд, менторууд хамтрагч байгууллагууддаа шаардлагатай сургалтуудыг цаг тухайд нь орж, зөвлөн чиглүүлж ажилласаар байна. Мөн

нийгэмд болж буй бүхий л асуудлууд дээр чимээгүй өнгөрөх биш дуу хоолойгоо илэрхийлж, хамтдаа сэтгэлгээг хөгжүүлэхийн тулд уриалан ажиллаа.

ТББ шинээр хэрхэн байгуулах, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, контент төлөвлөгөө боловсруулах чиглэлээр онлайнаар болон ганцаарчилсан сургалтаар мэдээлэл хүргэсэн.

Сошиал медиа маркетинг” сэдвээр хамтрагч байгууллагын төлөөллүүдэд 2 өдрийн сургалтыг Монложистикс Холдинг ХК-ийн Маркетингийн менежер М.Хосбаяр нь өөрсдийн брэндийг хэрхэн таниулах, сошиал орчинд хэрхэн маркетинг хийх талаар мэдлэгийг хүргэсэн.

NGO байгуулахад шаардагдах зүйлс, ажлын төлөвлөгөө боловсруулах, сайн дурын менежмент,баг хэрхэн үүсгэх гэх мэт олон чиглэлээр үе шаттай сургалтуудыг өгч ажилласан.

- Төрийн бус байгууллагууд үйл ажиллагаагаа санхүүжүүлэх зорилгоор хэрхэн хандив бүрдүүлэх тухай Гүйцэтгэх захирал Ч.Ганжавхлан хамтрагч байгууллагууддаа сургалт зохион байгууллаа.

### **Шамбала 2056**

Бид 2022 онд 500ш хайлаас мод тарьж нийслэлийн байгаль орчны газар болон хариуцах байгууллагад хүлээлгэж өгч байсан бол 2023 онд цөлжилтийн эсрэг нэн шаардлагатай мод тарих газрыг сонгож, үүний хүрээнд “Shambala 2056” төслийг хэрэгжүүлэгч мэргэжлийн байгууллагатай хамтарч ажиллах шийдэлд хүрсэн юм.

Шамбала инженеринг кампус нь Дорноговь аймгийн Эрдэнэ сум Ар цацын ус Төхөмийн хөндийд үйл ажиллагаагаа явуулж байна. Уг төслийн зорилго нь 2016 оноос 2056 он хүртэл 40 жилийн хугацаанд Дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилтуудын хүрээнд хуурай газрын экосистемийн урт хугацаанд хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг урлаг, технологи ашиглан бууруулахаар зорьж буй төсөл юм.

Монложистикс Групп 2023 оны 5 дугаар сард “Shambala 2056” Art’N Tech Land Art төслийг ивээн тэтгэж хамтын ажиллагааны гэрээ байгуулсан. Монложистикс Групп нь энэ төслийг дэмжин хамтарч ажилласнаар дараах үр нөлөөг байгаль, экологид бодитоор үзүүлж, холбогдох батламжийг гардаж авсан юм. Үүнд:

1. “CO<sup>2</sup> Нүүрс хүчлийн 220,309.09кг давхар ислийг боловсруулсан.
2. O<sup>2</sup> 367,181.8кг хүчилтөрөгч ялгаруулсан.
3. 1,255,871.2кг биомасс үүсгэсэн.

### **Төмөр замын тээвэр**

Монложистикс Групп нь уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн бага нөлөөтэй төмөр замын тээврээр уул уурхайн бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд анхаарч, энэ чиглэлд голлон ажиллаж байна. EcoTransIT World дээр жишээ болгон Улаанбаатар хотоос БНХАУ-ын Эрээн боомт хүртэл 100 ширхэг 20 футын чингэлэг буюу 1 цуваа вагоноор ачаа тээвэрлэхэд ялгаруулах хүлэмжийн хийн хэмжээг авто тээвэртэй харьцуулан үзэхэд энэхүү тооцооллоор авто зам нь төмөр замаас 50%-иар илүү хүлэмжийн хийг ялгаруулж байдгийг баталж байна.

Монложистикс Группийн охин компани болох Каус Аустралис ХХК 2023 онд нийт 16000 тонн ачааг төмөр замаар тээвэрлэсэн нь байгаль орчинд ээлтэй байхын төлөө, хүлэмжийн хийн ялгарлыг өөрсдийн үйл ажиллагааны хүрээнд багасгаж байгаа нэг том хэлбэр юм. Цаашид Монложистикс Групп Монгол улсын уул уурхайн экспортын тээврийг байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл хамгийн багатай тээврийн төрөл болох төмөр замын тээвэрт илүү анхаарч өөрийн эзэмшлийн тээврийн хөдлөх бүрэлдэхүүн болох вагон худалдан авахаар төлөвлөн, нийт 7,3 сая ам доллар буюу 25 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр урт хугацаанд төлөвлөн ажиллаж байна.

### Ложистик форум

Монложистикс Групп нь 2022 оноос эхлэн жил бүр уламжлал болгон тээвэр ложистикийн салбарын төлөөлөгчид болон төр ба хувийн хэвшлийг оролцуулсан салбарын хөгжил дэвшил, цаашдын боломж, ирээдүйн чиг хандлагыг хамтдаа хэлэлцэх “ЛОЖИСТИКС ФОРУМ”-ийг 2023 оны 5 сарын 4 -нд хоёрдох жилдээ амжилттай зохион байгууллаа.

Уг арга хэмжээний энэ удаагийн онцлог нь БНХАУ, ОХУ-ын болон дотоодын 500 гаруй тээвэр ложистикийн салбарын төлөөллүүдтэй хамтын ажиллагаагаа улам тэлж, ложистикийн салбарыг дараагийн шатанд гаргах олон сонирхолтой сэдвүүдийг хэлэлцлээ.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

<p>Овог, нэр: Г.Хишигбат Албан тушаал: “Монложистикс Холдинг” ХК-ийн Гүйцэтгэх захирал Гарын үсэг: ..... (Тамга/тэмдэг)</p>	<p>Овог, нэр: ..... Албан тушаал: “ХХК аудитын компанийн гүйцэтгэх захирал Гарын үсэг: ..... (Тамга/тэмдэг)</p>
---	---

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо: 2024-03-31

Овог, нэр: З.Шинэ-Од  
Албан тушаал: Санхүү эрхэлсэн захирал  
Гарын үсэг:



# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН 2023 ОН

# Агуулга

## 01

### Бидний тухай

Компанийн товч танилцуулга .....	4
Эрхэм зорилго, Алсын хараа, Үнэт зүйлс .....	5
Группийн бүтэц .....	6
Группийн түүхэн замнал .....	8
ТУЗ-ийн даргын мэндчилгээ .....	10
Гүйцэтгэх захирлын захидал .....	12
Онцлох тоон үзүүлэлтүүд .....	13
Онцлох санхүүгийн үзүүлэлт .....	14
Онцлох тээвэр .....	16
Онцлох үйл явдал .....	17

## 02

### Стратеги болон санхүүгийн зорилго

Алсын хараа 2030 .....	19
Бизнес модель .....	20
2023 оны стратеги .....	21
2023 оны хэрэгжүүлсэн стратегийн ажлууд.....	23
Бүрэн дижитал орчин .....	24
2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө .....	25

## 03

### Бидний үйл ажиллагаа

Дэлхийн тээвэр ложистикийн салбар .....	27
Монгол Улсын тээвэр ложистикийн салбар .....	28
Санхүүгийн үзүүлэлт .....	30
Групп гүйцэтгэл - Импорт .....	32
Групп гүйцэтгэл - Экспорт .....	34
Групп гүйцэтгэл - Транзит .....	34
Групп гүйцэтгэл - Бусад .....	35



## 04

### Тогтвортой хөгжил

Нийгэм ба байгаль орчин .....	37
Шамбала, Төмөр замын тээвэр .....	38
Нийгэм - Do Good Hub .....	39
ESOP Хуримтлалын хөтөлбөр .....	40
Хүний нөөцийн бодлого .....	41

## 05

### Засаглал

Хуулийн этгээдийн мэдээлэл, Хувьцаа эзэмшигчдийн бүтэц.....	44
Засаглалын бүтэц, үйл ажиллагаа .....	45
Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт, өөрийн үнэлгээ.....	46
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал .....	47
Төлөөлөн удирдах зөвлөл .....	48
Гүйцэтгэх удирдлагын баг .....	49
Охин компанийн удирдлагууд .....	50
Эрсдэлийн удирдлага .....	51
Дотоод аудитын тогтолцоо.....	53
Ногдол ашгийн тухай.....	54
Хувьцааны мэдээлэл.....	55

## 06

### Тайлан

Санхүүгийн тайлан .....	58
Тайлагналын зарчим.....	61
Тайлбар толь.....	62



**monlogistics**  
GROUP

# 01

## Бидний тухай

---

Үйл ажиллагааны жилийн тайлан 2023 он



## КОМПАНИЙН ТУХАЙ

Монложистикс Групп нь 2005 онд тээвэр зуучийн чиглэлээр үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол өдгөө 1 толгой компани, 9 охин компани, 180 орчим ажилтан, 163 орны 800 гаруй харилцагч түнш, дотоодын 1500 гаруй үйлчлүүлэгчтэй Монгол улсын тээврийн салбарын тэргүүлэгч байгууллага болсон байна.

Монложистикс Групп нь Монгол Улсын иргэдийн өдөр тутам хэрэглэдэг өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг импортлохоос эхлэн уул уурхайн түүхий эд бүтээгдэхүүнийг экспортлох, хөрш орнуудыг ачаа тээврээр холбох хүртэл импорт, экспорт, транзит, тракинг зэрэг тээвэр ложистикийн бүх төрлөөр олон улсын стандартад нийцсэн тээврийн цогц үйлчилгээг үзүүлсээр байна.

Монложистикс Холдинг ХК нь тээвэр ложистикийн цогц үйлчилгээ үзүүлэгч Группийн охин компаниудын бодлого, стратеги, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, тэдгээрт Хүний нөөц, Санхүү, Мэдээллийн технологи, Маркетинг, Стратеги, бизнес хөгжил, Ложистик гэсэн 6 чиглэлд менежментийн үйлчилгээ үзүүлдэг толгой компани юм.

## Эрхэм зорилго

Дэлхий рүү тэмүүлэх үндэсний брэнд

## Алсын хараа

Бид 2030 онд орчин үеийн дэд бүтэц, үйлчилгээний чанар дээр суурилсан цогц ложистик үйлчилгээг нэвтрүүлж, улмаар Монгол улсыг Ази Европыг холбосон ложистик төв болгоно.

## Үнэт зүйлс

Өндөр чадвартай, мэргэжлийн хамт олон

Ажилтан бүр өөрийгөө олж нээн, авьяас чадвараа суралцах их хүсэл эрмэлзлээр хөгжүүлэн, оюун ухаан, хүч хөдөлмөрөө харамгүй зориулснаар өөртөө болон байгууллагад амжилт бүтэл дагуулж, бусдадаа үлгэрлэн манлайлах замаар дараагийн залгамж манлайлагч нарыг тасралтгүй төрүүлдэг байна.

Бусдыг хүчирхэгжүүлэх манлайллын соёл

Манай ажилтан бүр тасралтгүй суралцан, мэдлэг оюунаа тэлж, мэргэжлийн болон ерөнхий ур чадвараар цаг үетэйгээ үргэлж нийцэж, дэлхийн өнцөг булан бүрийн аль ч компанид тэнцэн ажиллах чадамж бүхий зорилго нэгт баг хамт олны нэг хэсэг байна.

Хариуцлага, сахилга бат

Манай байгууллагын ажилтан бүр өөрийн хариуцсан ажлыг хийхдээ хувийн өндөр сахилга баттай байж, ажилдаа өөриймсөг сэтгэлээр хандаж, Монгол улсын хууль тогтоомж, Группийн дотоод үйл ажиллагааны стандартыг ёс зүйтэй мөрдөж, ямар ч ажлыг туйлын хариуцлагатайгаар, чанар стандартын дагуу гүйцэтгэдэг байна.

Шударга, ил тод байдал


Манай бүх үйл ажиллагаа том жижиг, их багаас үл хамааран үнэнч шударга байх зарчим дээр суурилан бүхий л оролцогч талуудад шаардлагатай мэдээллийг нээлттэй ойлгомжтой, үнэн зөвөөр цаг ямагт хүргэж байх болно.

Инновацлаг багийн сэтгэлгээ

Манай хамт олон инновац, бүтээлч сэтгэлгээрээ багийн үйл ажиллагааг тасралтгүй сайжруулан төгөлдөршүүлэхийн төлөө цаг үетэй хөл нийлүүлж, техник технологийн хөгжлийг хурдтай нэвтрүүлж, байнга шинийг санаачлагч багуудаас бүрдэнэ.



# ГРУППИЙН БҮТЭЦ





Үйл ажиллагааны жилийн тайлан 2023 он

# ДЭЛХИЙ РҮҮ ТЭМҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ БРЭНД

## ГРУППИЙН ТҮҮХЭН ЗАМНАЛ

Монголын Тээвэр зуучийн нэгдсэн холбоонд албан ёсны гишүүнээр элсэв.

**2006 ОН**

Монгол улсын Гаалийн ерөнхий газраас Гаалийн зуучлагчийн тусгай зөвшөөрлийг авав.

**2010 ОН**

Олон улсын тээвэр зуучийн нэгдсэн холбоонд албан ёсны гишүүнээр элсэв.

**2014 ОН**

Rebranding “Upgrade 10” төслийг амжилттай эхлүүлэв.

**2016 ОН**

**2005 ОН**

Монложистикс Ворлдвайд ХХК анхны ууган компани байгуулагдав.



**2009 ОН**

Төмөр замын аюулгүй ажиллагааны тусгай зөвшөөрлийг хүлээн авав.



**2011 ОН**

Монголын гаалийн зуучлагчдын нэгдсэн холбооны гишүүнээр элсэв.



**2015 ОН**

ISO 9001:2008 Олон улсын чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэв.





Оюу толгой компанийн албан ёсны тээврийн компаниар шалгарав.

2018 ОН



Монложистикс Холдинг ХХК Толгой компани байгуулагдав.

2020 ОН



Түүхий эдийн экспортын тээврийг эхлүүлж, Каус Аустралис ХХК-ийг байгуулав.

2022 ОН



Монложистикс Холдинг ХК Do good HUB ТББ-ыг байгуулав.

2023 ОН

2017 ОН

Бүх тээврийг даатгалд хамруулах үйлчилгээг нэвтрүүлэв.



2019 ОН

Монложистикс Транзит ХХК байгуулагдав.



2021 ОН

Портфолио өргөжилт хийж, 3 охин компаниа байгуулав.



2023 ОН

Монложистикс Холдинг ХХК Олон нийтэд нээлттэй компани болов.



“

... МХБ-ИЙН  
**ТОП-20**  
ИНДЕКСИЙН БАГЦАД  
БАГТАЖ, ХӨРӨНГИЙН  
ЗАХ ЗЭЭЛ, ТЭЭВЭР  
ЛОЖИСТИКИЙН  
САЛБАРТ ТҮҮХИЙН  
НЭГЭН ШИНЭ ХУУДСЫГ  
ЭХЛҮҮЛСЭН ҮЙЛ ЯВДАЛ  
БОЛЛОО...

”



## ТУЗ-ИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ

Монгол Улсын тээвэр ложистикийн салбарын эрхэм хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэн мэндчилье!

2023 он Монложистикс Группийн хувьд Монгол улсын тээврийн салбарын шинэ үеийг тодотгосон, хөгжлийн гарц гаргалгааг илтгэсэн олон ололт амжилтаар дүүрэн жил болж өнгөрлөө.

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын дунд тээврийн төрөлжсөн Групп компани шинээр орж ирсэн төдийгүй, нээлттэй компани болсноос хойш 3 сарын дотор Монголын хөрөнгийн биржийн ТОП-20 индексийн багцад багтаж, Монгол улсын хөрөнгийн зах зээл, түүгээр зогсохгүй тээвэр ложистикийн салбарт нэгэн түүхийн шинэ хуудсыг эхлүүлсэн үйл явдал боллоо.

Монложистикс Холдинг ХК нь Засгийн газрын баталсан “Алсын хараа-2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого” “Боомтын сэргэлтийн 4 зорилтыг дэмжих зорилгоор бизнесийн үйл ажиллагаандаа уг бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, богино хугацаанд хэрэгжих боломжтой салбарын гол хэсэг байхаар өөрсдийн 2030 алсын хараагаа нэгтгэн чиглүүлж, олон нийтэд нээлттэй компани болж, татан төвлөрүүлсэн хөрөнгө оруулалтаараа дэд бүтцийг дэмжих төсөл хөтөлбөрүүдийг тасралтгүй эрэлхийлсээр байна.

Монложистикс Групп 18 жилийн туршид бүтээсэн үнэт зүйлсээ цаашид улам бататгаж, тасралтгүй сайжруулахын зэрэгцээ салбартаа төдийгүй Монгол улсын хөгжлийн түүхэнд хамтдаа бичилцэх их үйлсийг удирдлагын манлайллаар тодруулж, компанийн бүхий л хөрөнгө оруулагчдын өмнө хүлээх үүрэг хариуцлага, байгаль орчинд сөрөг нөлөөгүй ажиллах шаардлагын тэнцвэртэй харьцааг нэн тэргүүнд баримтлан, бүх цаг үед хичээн зүтгэсээр байх болно.

Хүндэтгэсэн,

**Л.ГАНЗОРИГТ**

ТУЗ-ИЙН ДАРГА, ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ



## ГРУППИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ЗАХИДАЛ

Монложистикс Групп нээлттэй компани болсноос хойших үйл ажиллагааны анхны жилийн тайлангаараа эрхэм хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч та бүхэнтэй дахин уулзахад таатай байна.

Монложистикс Группийн хамтран ажиллагч байгууллага, үнэнч үйлчлүүлэгчдийн хамтын ажиллагаа, хүчин чармайлтын үр дүнд бидний нийт тээвэрлэсэн ачаа тээврийн хэмжээ 1 сая тоннд хүрсэн нь тээврийн компанийн түүхэн тоог шинэчлэн тогтоосон амжилттай жил болж өнгөрлөө.



**... МОНГОЛ УЛСЫН БОГИНО, ДУНД  
ХУГАЦААНЫ МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ЭЕРЭГ  
ХҮЛЭЭЛТ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХЭД  
ТААТАЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЖ БАЙНА...**



Бидний үүсгэн байгуулж, хөгжүүлсэн Монложистикс Группийн 10 компанийн бүрдүүлж буй энэхүү үр дүнг бий болгоход тууштай хүчин чармайлт гаргасан мэргэжлийн хамт олон, үргэлж биднийг сонгон үйлчлүүлдэг үйлчлүүлэгч, итгэж дэмждэг хувьцаа эзэмшигчид болон үргэлж найдвартай мэргэжлийн байж чаддаг хамтрагч түншүүддээ талархал илэрхийлье!

Монложистикс Групп нь IPO хийх замаар хөрөнгө татан төвлөрүүлсэн мөн санхүүгийн болон бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтүүдийг амжилттай хийсний үр дүнд нийт 25 орчим тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгөтэй болж, аливаа ер зээлгүй 2023 оныг амжилттай дуусгалаа. Монгол улсын богино, дунд хугацааны макро эдийн засгийн эерэг хүлээлт нь мөн хөрөнгө оруулалт хийхэд таатай орчныг бүрдүүлж байгаа учраас бид удахгүй олон шинэ мэдээ, бүтээгдэхүүн үйлчилгээтэйгээр үйлчлүүлэгч хэрэглэгч, хөрөнгө оруулагч нартайгаа уулзана гэдэгт итгэлтэй байна.

Хүндэтгэсэн,

**Г. ХИШИГБАТ**  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



## ОНЦЛОХ ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тээвэрлэсэн ачааны өсөлт

^ **+163%**

Тээврийн салбарын нийт ачааны өсөлт

^ **+70%**

Борлуулалтын орлогын өсөлт

^ **+55%**

Эздийн өмчийн өгөөж /ROE/

**19%**

Урт хугацааны зээл

**0 төгрөг**

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө \*

**25 тэрбум төгрөг**

\* Богино хугацаат хөрөнгө оруулалт агуулсан дүн



## ОНЦЛОХ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

ҮЗҮҮЛЭЛТ	Хэмжих нэгж	Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан 2021 (restated)	Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан 2022 (restated)	Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан 2023	Өсөлт (бууралт)
<b>ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ</b>	мян.кг	314.55	395.84	1,042.33	163%
<b>ОРЛОГЫН ҮР ДҮН</b>					
Борлуулалтын орлого	сая.төг	89,479	136,095	210,361	55%
Нийт ашиг	сая.төг	8,662	16,547	18,108	9%
Үйл ажиллагааны ашиг	сая.төг	5,150	11,419	9,290	(19%)
<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>сая.төг</b>	<b>4,463</b>	<b>9,392</b>	<b>8,363</b>	<b>(11%)</b>
<b>БАЛАНС</b>					
Эргэлтийн хөрөнгө	сая.төг	24,508	39,725	54,577	37%
Эргэлтийн бус хөрөнгө	сая.төг	1,527	2,372	3,031	28%
<b>Нийт хөрөнгө</b>	<b>сая.төг</b>	<b>26,034</b>	<b>42,097</b>	<b>57,609</b>	<b>37%</b>
Нийт өр төлбөр	сая.төг	8,527	16,959	14,169	(16%)
Нийт эздийн өмч	сая.төг	17,507	25,138	43,439	73%
<b>Нийт эздийн өмч ба өр төлбөр</b>	<b>сая.төг</b>	<b>26,034</b>	<b>42,097</b>	<b>57,609</b>	<b>37%</b>
<b>МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>					
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(5,997)	9,382	4,480	(52%)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	1,129	(1,232)	(2,390)	94%
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	1,420	(492)	6,037	(1327%)
Бусад мөнгөн гүйлгээ	сая.төг	(14)	725	(203)	(128%)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(3,462)	8,383	7,924	(5%)
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>сая.төг</b>	<b>9,277</b>	<b>5,816</b>	<b>14,198</b>	<b>144%</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>сая.төг</b>	<b>5,816</b>	<b>14,198</b>	<b>22,122</b>	<b>56%</b>
<b>ТАТВАР ТӨЛӨЛТ</b>					
НӨАТ	сая.төг	1,470	2,820	3,152	12%
ААНОАТ	сая.төг	879	1,385	1,275	(8%)
<b>Нийт татвар төлөлт</b>	<b>сая.төг</b>	<b>2,349</b>	<b>4,205</b>	<b>4,427</b>	<b>5%</b>

# ОНЦЛОХ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

## Харьцаа үзүүлэлтүүд

Санхүүгийн харьцаа үзүүлэлт   Financial ratio		2021	2022	2023
Нийт ашгийн хувь   Gross margin	хувь	9.70%	12.20%	8.60%
Цэвэр ашгийн хувь   Net margin	хувь	5.00%	6.90%	4.00%
Өөрийн хөрөнгийн өгөөж   Return on equity	хувь	25%	37%	19%
Өөрийн хөрөнгийн харьцаа   Solvency ratio	хувь	59%	69%	51%
Үйл ажиллагааны эргэц   Operation cycle	хоног	54.84	87.65	71.94
Эргэлтийн харьцаа   Current ratio	нэгж	3.19	2.37	3.98
Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа   Cash ratio	нэгж	2.53	2.01	3.43
Хувьцааны харьцаа үзүүлэлт   Share ratio		2021	2022	2023
Нэгж хувьцаанд ногдох ашиг   Earnings per share	төгрөг	180,884.77	364,054.90	14.81
Эргэлтэнд байгаа хувьцаа   Number of shares issued **	ширхэг	22,432	22,432	395,858,822
Хувьцааны хаалтын ханш   Share price at year-end ***	төгрөг	4,358.45	4,358.45	180.39
Зарласан нэгж хувьцаанд ногдох ашиг   Proposed dividend per share	төгрөг	-	-	7.58

\*\* 2023 онд хувьцаат компани болохтой холбогдуулан нэгж хувьцаааг 15000 ширхэг болгон хувааж, нэмж 59,378,822 ширхэг хувьцаа нэмж гаргасан

\*\*\* 2021, 2022 оны хувьцааны хаалтын ханш нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийн сангийн нэрлэсэн үнэ

## ОНЦЛОХ ТЭЭВЭР



### Монложистикс Ворлдвайд Компани

2023 оны 1-р сарын 28-нд Улаанбаатар хотоос БНХАУ-ын Шижиажуан хот руу анхны уул уурхайн бус бүтэн цуваа /50 чингэлэг/ экспортын ачааг амжилттай хийж гүйцэтгэлээ.



### Монложистикс Ворлдвайд Компани

2023 оны 4-р улиралд Австри улс руу агаараар “УРАНЫ ДЭЭЖ” болох аюултай ачааг амжилттай тээвэрлэж гүйцэтгэлээ.



### Монложистикс Транзит Компани

Монложистикс Тракинг Компанитай хамтран БНХАУ-ын Шандунг мужаас ОХУ хүртэл том оврын ачааны машинаар 7000 км “Автозамын Транзит” тээврийг зохион байгууллаа.



### Монложистикс Тракинг Компани

Монгол Улс, БНХАУ болон ОХУ-ын Засгийн газар хоорондын БНХАУ-ын Шиньжиан Уйгарын Үрэмч хотоос 2023 оны 9-р сарын 22-с эхэлсэн 3 улсын туршилтын тээвэрт амжилттай оролцлоо.



### Монложистикс Карго Компани

Цахим худалдааны Cheerah брэнд нь 2023 оны 10-р сард гар утасны аппликейшнээ танилцуулж, 50,000 гаруй бүртгэлтэй хэрэглэгчтэй боллоо.



### Монложистикс Транс Сервис Компани

ОХУ-ын Эрхүү хотод үйл ажиллагаа явуулдаг ба 2023 онд Монгол Улсаас ОХУ руу анхны реэкспортын чингэлэг тээврийг зохион байгууллаа.

# ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



## Ложистик форум

Монложистикс Групп нь тээвэр ложистикийн салбарын төлөөлөгчид болон төр ба хувийн хэвшлийг оролцуулсан салбарын хөгжил дэвшил, цаашдын боломж, ирээдүйн чиг хандлагыг хамтдаа хэлэлцэх “ЛОЖИСТИК ФОРУМ”-ыг 2023 оны 5-р сард 2 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа.



## Гадны шагнал

Монложистикс Групп нь 2023 оны 12-р сарын 15-нд олон улсын “APAC INSIDER” Business Awards сэтгүүлийн “Best International Import/Export Transportation Business 2023 - Mongolia” шагналыг хүртлээ.



## Investment Expo 2023

Мандал Санхүүгийн нэгдлээс жил бүр зохион байгуулдаг Монголын хамгийн том хөрөнгө оруулагч нарын цуглардаг арга хэмжээ болох “Инвестмент Экспо 2023” арга хэмжээнд Монложистикс Групп нь 2 дахь жилдээ ивээн тэтгэгчээр оролцож, 1000 гаруй хүнд тээвэр ложистикийн салбарын мэдээллийг амжилттай хүргэлээ.



## Ам доллароор баталгаажсан бонд

Монгол улсын тээвэр ложистикийн компаниудаас анх удаа 2 тэрбум төгрөг бүхий ам.доллароор баталгаажсан хаалттай бондыг гаргаж, хөрөнгө оруулагч нартаа 2023 оны 7-р сард бондын эргэн төлөлтийг амжилттай хааж дуусгалаа.



## Нээлттэй хувьцаат компани

Бид 2023 оны 6-р сарын 27-нд СЗХ-оос олон нийтэд нээлттэй компани болох зөвшөөрлөө авч, 9-р сарын 11-нд “Цан цохих ёслол” Монголын хөрөнгийн бирж дээр болж, анхдагч захиалгад нийт 1307 хөрөнгө оруулагч оролцож, захиалга 101.68%-иар амжилттай биеллээ.



## Сингапур улсын CNA ярилцлага

Сингапур улсын үндэсний CNA телевизэд Монложистикс Холдинг ХК-ийн Гүйцэтгэх Захирал Г. Хишигбат 2023 оны 10-р сард урилгаар “Монгол Улсын тээвэр ложистикийн салбарын цаашдын ирээдүй, өсөлт хөгжлийн тухай” ярилцлага өглөө.

# 02

## Стратеги болон санхүүгийн зорилго

---

Үйл ажиллагааны жилийн тайлан 2023 он



# АЛСЫН ХАРАА 2030

Бид орчин үеийн дэд бүтэц, үйлчилгээний чанар дээр суурилсан цогц ложистик үйлчилгээг нэвтрүүлж улмаар Монгол улсыг Ази, Европыг холбосон ложистик төв болгоно.

Уг алсын харааг биелүүлэх урт хугацааны стратеги, зорилгын хүрээнд дараах ажлыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.




## БИЗНЕС МОДЕЛЬ

Олон улсад нийлүүлэлтийн сүлжээг удирдах хэлбэр 1PL загвараас 5PL хүртэл хөгжөөд буй бөгөөд Монложистикс Группийн хувьд өөрийн харилцагч байгууллагуудын ачааг тээвэрлэх тээврийн шинэ маршрутыг хөгжүүлснээр геополитикийн хүндрэлээс үүсэж буй тээвэрлэлтийн хүндрэл бэрхшээлийг даван туулах, хамтран ажиллагч түншийн харилцаа болон дэд бүтцийн ашиглалтыг нэмэгдүүлснээр тээвэрлэлтийн хямд бөгөөд хурдан шуурхай үйлчилгээг санал болгож, өөрийн 3PL бизнес моделийг хөгжүүлэн ажиллаж байна.

**3PL** загвар нь ханган нийлүүлэлтийн гинжин хэлхээний олон асуудлыг хариуцдаг мэргэжлийн ложистикийн үйлчилгээ үзүүлэгч компаниас Ачааг хүлээн авах, Тээвэрлэх, Хадгалах, Савлах, Шошголох, Хүргэлт хийх гэх мэт үйлчилгээг авч байгаа хэлбэр юм. 3PL үйлчилгээ үзүүлэгчид нь илгээгч болон тээвэрлэгчдийн хооронд зохион байгуулагчийн үүрэг гүйцэтгэж, үр ашгийг оновчтой болгох, зардлыг бууруулах, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхийн тулд нийлүүлэлтийн гинжин хэлхээний ложистикийг удирддаг.

3PL үйлчилгээ үзүүлэгч компаниудын үйлчилгээг ашигласнаар бизнес эрхлэгчид үндсэн бизнестээ анхаарлаа төвлөрүүлж, ложистикийн хэрэгцээгээ туршлагатай мэргэжилтнүүдэд даатгаж чаддаг.



### Олон улс дахь тээвэр ложистикийн үйлчилгээ

Тээврийн захилга - Ачааг агуулахаас авах үйлчилгээ - Агуулах  
Бичиг баримт болон гаалийн үйлчилгээ - Цуглуулбар ачааны тээвэр  
Худалдан авалтын захиалгын үйлчилгээ - Түр агуулахын үйлчилгээ  
- Даатгал



**Тээвэр**  
Туслан гүйцэтгэгч

### Монгол улс дахь тээвэр ложистикийн үйлчилгээ

Агуулах - Хүргэлт ба савлах - Түр агуулахын үйлчилгээ  
Цуглуулбар ачааны түгээлт - Хаягжуулалт - Түгээлт - Бичиг  
баримт болон гаалийн үйлчилгээ - Цахим худалдааны түгээлт -  
Нүүрстөрөгчийн ялгаруулалтын тайлан - Нийлүүлэлтийн сүлжээний  
инновац - 4PL үйлчилгээ



Илгээгч

Бидний гол нөөц

Хүлээн авагч

Баг хамт олон - IT систем - Салбарын туршлага - Стандартын дагуух процесс үйл ажиллагаа - Тээвэрлэгчийн түншлэл - Олон улс дах салбар байгууллага

■ Бидний үзүүлдэг үйлчилгээ

■ Үзүүлэхээр төлөвлөж буй үйлчилгээ

## 2023 ОНЫ СТРАТЕГИ

Монложистикс Группийн бүтэц зохион байгуулалтын хүрээнд

**Толгой компани** өсөлтийн 5 стратегийг хэрэгжүүлж

**Охин компаниуд**

тогтвортой хөгжлийн 2 стратегийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

### ӨСӨЛТ



### ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ







### 1. Брэндинг, ПР

Монложистикс Групп нь брэндинг, ПР стратегийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын тээвэр ложистикийн салбарын тэргүүлэх байр сууриа бататгах, урт хугацаанд олон улсад өрсөлдөх чадварыг бий болгох зорилгоор инновацлаг, орчин цагийн тэргүүлэгч брэндийг дотооддоо болон бүс нутгийн хэмжээнд бий болгохоор ажиллаж байна.



### 2. Засаглал, Хүний нөөцийн хөгжил

Богино болон дунд хугацаанд компанийн сайн засаглалыг хөгжүүлэх ажлын хүрээнд Монгол улсад мөрдөгдөж буй хууль эрх зүйн актууд болон олон улсын стандартын дагуу бизнесийн үйл ажиллагаа явуулах мөн хууль тогтоомжид нийцүүлэн хөдөлмөрийн олон талт харилцаанд оролцогч бүх талуудын эрх зүйн тэнцвэртэй байдлыг хангасан зохицуулалт, хүний нөөцийн менежментийн нэгдсэн бодлого, стратегийг байгууллагын соёлд нийцүүлэн хэрэгжүүлж, тээвэр ложистикийн салбарт мэргэшсэн баг хамт олныг бүрдүүлэхээр ажиллаж байна.



### 3. Хатуу болон зөөлөн дэд бүтэц

Тээвэр ложистикийн бизнесийн тасралтгүй байдал нь дэд бүтцийн хүчин чадал, ашиглалтаас шууд хамааралтай байдаг бөгөөд Монложистикс Групп нь бизнесийн үр ашгийг нэмэгдүүлэх, эрсдэлийг бууруулах, өрсөлдөөний давуу талыг бий болгох зорилгоор богино болон дунд хугацаанд дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнд хөрөнгө оруулалт хийж, өөрийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.



### 4. Бүрэн дижитал орчин

Тээвэр ложистикийн салбар нь бусад салбарын адил орчин үеийн технологийн шийдэлтэй уялдан, өрсөлдөөний давуу талыг бий болгож байна. Иймд богино болон дунд хугацаанд дотооддоо хөгжүүлсэн тээврийн менежментийн системийг дараагийн шатанд хөгжүүлж, бизнесийн бүтээмжийг нэмэгдүүлэх болон системийн аюулгүй байдлыг ханган ажиллахаар зорьж байна.



### 5. Хөрөнгө оруулалт ба санхүүжилт

Монложистикс Групп нь хөрөнгийн зах зээлээс урт болон богино хугацааны санхүүжилт татан төвлөрүүлэх, дотоодын болон олон улсын банк санхүүгийн байгууллагуудтай нягт хамтран ажиллах замаар бага хүүтэй, урт хугацааны санхүүжилт татах ажлыг зохион байгуулж, ирээдүйд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн үр ашгийг нэмэгдүүлэх болон санхүүгийн тогтвортой байдлыг бий болгохоор төлөвлөн ажиллаж байна.



### 6. Үйлчилгээний чанарын соёл

Монложистикс Групп нь үйлчилгээний стандарт болон чанарын тогтолцоог хэрэглэгчийн хэрэгцээ шаардлага дээр тулгуурлан сайжруулах, үйлчилгээний чанарын функцийг олон улсын жишигт хүргэхээр ISO-9001:2015 Чанарын удирдлагын тогтолцооны стандартыг нэвтрүүлэхээр ажиллаж байна.




### 7. Зах зээлд эзлэх хувийг өсгөх

Зах зээлд эзлэх байр сууриа томруулах, ашиг орлогоо нэмэгдүүлэхийн тулд охин компани тус бүрийн онцлог шинжийг тодорхойлж, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах, ложистикийн эко системийг бүрдүүлэх, өсөлтийн стратегийг хэрэгжүүлдэг "Boston Consulting Group ("BCG" гэх)"-ийн матрицаар охин компаниудыг үнэлэн ангилалд хамруулж, тус матрицын дагуу зах зээлийн өсөлт болон зах зээлд эзлэх байр суурь гэсэн 2 хүчин зүйлд тулгуурлан үйл ажиллагаа болон бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх стратегийг баримтлан ажиллаж байна.


## 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН СТРАТЕГИЙН ТОМООХОН АЖЛУУД

 Олон нийтэд нээлттэй компани боллоо.




 Хөрөнгө оруулалтыг экспорт болон транзит тээвэрт төвлөрүүллээ.



 Портфолио чанаржилт буюу охин компаниудын зах зээлд эзлэх хувийг нэмэгдүүллээ.



 Вагон болон терминалын судалгааг боловсруулан ажиллаа.



## БҮРЭН ДИЖИТАЛ ОРЧИН

Монложистикс Холдинг нь бүрэн дижитал шилжилтийг эхлүүлсэн бөгөөд энэ хүрээнд Групп болон нэгдлийн охин компаниудын хүрээнд өдөр тутмын дотоод үйл ажиллагааг автоматжуулах, бүтээмжийг сайжруулах, цаасны хэрэглээг халж, байгальд ээлтэй байх зорилгоор дотоод ERP системийг нэвтрүүлэх, хөгжүүлэх төслийг эхлүүлсэн.

Ложистикийн үйл ажиллагааг хурдан шуурхай, алдаагүй, мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэх зорилгоор нэгдсэн тээвэр ложистикийн систем болох LMS (Logistics Management System)-ийг хөгжүүлж, үйл ажиллагаандаа үе шаттайгаар нэвтрүүлэн ажиллаж байна. Мөн цаашид ложистикийн салбарт үйл ажиллагаа явуулж буй бусад компани, аж ахуй нэгжүүдэд тус системийг нэвтрүүлэх, түүнийг даган бий болох салбарын үр өгөөж, нөлөөллийг өсгөх эрхэм зорилготой ажиллаж байна.



### The Modules of LMS

Цаашид бид LMS системийг сайжруулан хөгжүүлж, чадамжуудыг нэмэх, ашиглалтыг нэмэгдүүлэх байдлаар тасралтгүй хөгжүүлж, өөрсдийн олон улс дахь салбар нэгж, компаниуд болон хамтрагч олон улсын компаниудын системүүдтэй integration хийх замаар системийн цар хүрээг томруулж, хоорондын хамтын ажиллагааг хялбарчлах, уян хатан ухаалаг болгож, олон улсын түвшинд ашиглагдах нэгдсэн платформ болгон хөгжүүлэх зорилгыг тавин ажиллаж байна.

Цахим шилжилтийн хүрээнд ложистикийн салбар цахимжих, өндөр хөгжсөн техник технологийг өдөр тутам болоод салбарт ашиглах хэрэгцээ шаардлага өндөр байгаа учраас бид салбартаа түүчээлэн эхлүүлж, цахим өөрчлөлтийг бий болгох, үр өгөөжийг нэмэгдүүлэх, цар хүрээг тэлэх зорилгын хүрээнд IT багийн нөөцийг чадавхжуулан хүчирхэгжүүлж, өмнөх жилээс 56%-иар өргөтгөлөө. Ингэснээр бид өөрсдийн хүчээр 100% дотооддоо LMS систем, түүнийг дагах олон туслах модуль, программуудыг хөгжүүлж амжилттайгаар нэвтрүүлж, үе шаттайгаар ашиглаж эхэллээ. Мөн орчин цагийн программ хөгжүүлэлт болон IT Төслийн менежментийн шилдэг аргачлалууд болох AGILE, Scrum-ийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байгаа нь бас нэгэн томоохон өөрчлөлтүүдийн нэг боллоо.



Монложистикс Карго ХХК (охин компани) нь цахим худалдааны платформ үйл ажиллагаандаа хөгжүүлж, Sheerah брэндийг нэвтрүүлэн ашиглаж байна. Бид e-commerce цахим хуудас болон IOS, Android үйлдлийн систем дээр бүрэн ажиллах гар утасны аппликейшнийг хөгжүүлсэн бөгөөд 2023 оны эцсийн байдлаар 50,000 гаруй хэрэглэгчтэй болж, нийт 8000 ширхэг бараа бүтээгдэхүүнийг хэрэглэгчийн гар дээр хүргэсэн байна.

# 2024 ОНЫ ЗОРИЛТ БОЛОН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монложистикс групп нь шинээр компани үүсгэн байгуулан хөгжүүлж зах зээл дээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй компани худалдан авах арга замуудаар өөрийн зах зээлд эзлэх байр сууриа тэлэх зорилготойгоор судалгааг эхлүүлэн ажиллаж байна.

## 2024 оны санхүүгийн төлөвлөгөө

Хүлээлт 2024 (тэрбум.төгрөг)	2023 гүйцэтгэл	2024 төлөвлөгөө
Цэвэр ашиг	8.4	13-15
Цэвэр ашгийн хувь	4.1%	5%-5.5%

## 2024 оны санхүүгийн төлөвлөгөөний суурь таамаглал

Монложистикс групп нь жил бүрийн 11-р сарын эхэнд дараагийн 3 жилийн бизнес төлөвлөгөөг боловсруулан мөрдөн ажилладаг. 2024 оны бизнес төлөвлөгөөний эдийн засгийн өсөлтийг 6%, ам.долларын жилийн дундаж ханшийг 3592 төгрөг, Монгол улсын ложистикийн салбарын өсөлтийг 20% байхаар төлөвлөсөн. Ирэх жилийн Группийн төлөвлөгөөний цэвэр ашгийн өсөлтийг транзит тээвэр болон импортын тээврийн тооны өсөлт бүрдүүлж байна. Мөн IPO-оор татан төвлөрүүлсэн хөрөнгөөр худалдан авахаар төлөвлөсөн тавцант вагоныг 2024 оны 3-р сард үйл ажиллагаандаа ашиглаж эхлэхээр 2024 бизнес төлөвлөгөөнд тусгасан. Монложистикс

групп нь дотооддоо шинээр хөгжүүлж болон зах зээл дээр хэдийн байршсан компани худалдан авах арга замуудаар зах зээлийн эзлэх байр сууриа тэлэхээр төлөвлөн судалгааг эхлүүлэн ажиллаж байна.

## Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан

Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө	Дүн (сая.төгрөг)
Хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалт	8,062
Эргэлтийн хөрөнгө	2,923
<b>Нийт</b>	<b>10,985</b>

## Зарцуулалтын тайлан:

- Хөдлөх бүрэлдэхүүнийг худалдан авах ажиллагаа гэрээний шатанд явж байгаа учир зарцуулагдаагүй байна.
- Эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор 850 сая төгрөг зарцуулсан байна.



# 03


## Бидний үйл ажиллагаа

Үйл ажиллагааны жилийн тайлан 2023 он



# ДЭЛХИЙН ТЭЭВЭР ЛОЖИСТИКИЙН САЛБАР

Дэлхийн ложистик салбарын орлогын өсөлт үргэлжилсээр байгаа бөгөөд 2022 онд 7.98 их наяд ам.доллар байсан бол 2023 онд 12.2% өсөж 8.96 их наяд ам.долларт хүрсэн байна. 2030 он хүртэл салбарын орлогын жилийн дундаж өсөлт 10.7% болж 18.2 их наяд ам.долларт хүрнэ гэсэн тооцоолол байна. Ази номхон далайн бүс 2023 оны байдлаар салбарын нийт орлогын 44% буюу 3.9 их наяд ам.долларыг бүрдүүлж байсан бол 2030 он гэхэд 48% буюу 8.7 их наяд ам.долларыг бүрдүүлэх төлөвтэй байна.



<https://www.precedenceresearch.com/logistics-market>

<https://app.terminal.freightos.com>

Салбарын зах зээлд эергээр нөлөөлж буй гол хүчин зүйлүүдийн нэг нь цахим худалдааны салбарын хурдацтай хөгжил, өндөр хурдны интернэтийн хүртээмж сайжирч байгаа явдал юм.

Салбарын нөхцөл байдлыг илэрхийлэх томоохон үзүүлэлт бол далайн тээврийн үнийн индекс байдаг. 2021-2022 онд Covid 19 цар тахалтай холбоотой засгийн газрууд мөнгө тарааж зах зээл дээрх мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлснээр худалдан авалт нэмэгдэж далайн тээврийн эрэлт өсөж далайн тээврийн үнэ 11 мянган ам.доллар хүрч байсан нь өнгөрсөн үеийн дундаж үнээс 7.9 дахин өссөн үзүүлэлт юм. 2023 онд далайн тээврийн дундаж үнэ 1737 ам.доллар болон буурч, цар тахлын өмнөх үеийн хэвийн нөхцөл байдалд ирсэн юм. Гэвч геополитикийн асуудлаас үүдэн далайн тээврийн үнэ дахин өсөх хандлагатай байгаа юм.

Далайн тээврийн үнийн хэлбэлзэл ложистикийн томоохон компаниудад хэрхэн нөлөөлснийг 2023 оны санхүүгийн үзүүлэлтээр харвал:

тэрбум ам.доллар

Далайн тээврийн топ	Борлуулалтын орлого			Цэвэр ашиг		
	2022	2023	Өөрчлөлт	2022	2023	Өөрчлөлт
CMA CGM	74.5	47.0	(36.9%)	24.8	3.6	(85.3%)
Maersk	81.5	51.1	(37.3%)	29.2	3.9	(86.6%)
COSCO Shipping	58.1	23.7	(59.2%)	19.0	3.9	(79.4%)

Дэлхийн топ	2022	2023	Өөрчлөлт	2022	2023	Өөрчлөлт
DSV	33.7	21.9	(35.0%)	2.5	1.7	(32.0%)
FedEx	90.0	87.9	(2.3%)	4.1	4.0	(2.4%)
DHL	102.5	89.1	(13.1%)	6.1	3.8	(37%)

## САЛБАРЫН ИРЭЭДҮЙН ЧИГ ХАНДЛАГА

### Ногоон ложистик


Сүүлийн жилүүдэд байгаль орчныг хамгаалах асуудалд нийгэм ихээхэн анхаарал хандуулж байгаа бөгөөд ногоон ложистик гэдэг нь дэд бүтэц, ханган нийлүүлэгч, хадгалах зайг оновчтой болгож илүү үр ашигтай бөгөөд компанийн үйл ажиллагаанд нөлөөлөхгүйгээр байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, ялгарч буй нүүрс төрөгчийн хэмжээг багасгах юм.

### Хиймэл оюун ухаан болон автоматжуулалт

Ложистикийн салбарт автоматжуулалт болон робот, техникийн хэрэглээ нэмэгдэх төлөвтэй байна. Автоматжуулалт нь өгөгдөл оруулах, баглаа боодол, захиалга боловсруулах зэрэг давтагдах ажлуудыг автоматжуулах боломжтой. Мөн робот, техник нь барааг зөөвөрлөх, ялангуяа томоохон агуулах, түгээлтийн төвүүдэд туслах боломжтой юм. Түүнчлэн хиймэл оюун ухааныг ашиглан түлшний зардлыг бууруулах, хүргэлтийн хугацааг сайжруулах, жолоочийн аюулгүй байдлыг нэмэгдүүлэх, хүргэх маршрутааг оновчтой болгох гэх мэт олон давуу тал үүснэ хэмээн үзэж байгаа юм.

# МОНГОЛ УЛСЫН ТЭЭВЭР ЛОЖИСТИКИЙН САЛБАР

Сая тонн



Эх сурвалж: www.1212.mn

Монгол улсын нийт ачаа эргэлтийн тоо хэмжээ 2023 онд 103 сая тонн хүрч өмнөх мөн үетэй харьцуулахад 70% өссөн байна. Эргэлтийн тоо хэмжээний өсөлтийг тээврийн төрлөөр харвал авто замын тээвэр 116% өсөж 71.3 сая.тн, төмөр замын тээвэр 16.7% өсөж 32.4 сая.тн, агаарын тээвэр 34% буурч 9 мянган.тн байна.

Нийт ачаа эргэлтийн 76% буюу 78.8 сая.тонныг экспорт эзэлж байна. Экспортын 88%-ийг буюу 69.6 сая.тонныг дан ганц нүүрсний экспорт бүрдүүлж байгаа юм. 2023 онд нүүрсний экспорт өмнөх оны үеэс 119% өссөн байна.

2023 оны ачааны эргэлтийн өсөлт нь тээврийн салбарын орлогод томоохон өсөлт авчирсан ба өмнөх оны үеэс 52%-ийн өсөлт үзүүлж, 6.7 их наяд төгрөгт хүрсэн юм.

Салбарын орлогын өсөлтийг тээврийн төрлөөр салгаж үзвэл авто замын тээврийн орлого 47% өсөж 4.7 их наяд төгрөг, төмөр замын тээврийн орлого 50 хувь өсөж 1.1 их наяд төгрөг, агаарын тээврийн орлого 83.6% өсөж 942 тэрбум төгрөг боллоо.

Монгол улс “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд боомтуудын хүчин чадлыг 3 дахин

нэмэгдүүлэх сэргээх болон өргөтгөх ажлууд эхэлсэн ба боомтуудын үйл ажиллагаа сайжирснаар экспортыг өсгөх боломж улам бүр нэмэгдэхээр байгаа юм. Нөгөө талаас 2024 онд БНХАУ манай улсаас импортлох нүүрсний хэмжээг 100 сая.тонн болгохоор дэд бүтцийн бүтээн байгуулалт хийж байна.



Үйл ажиллагааны жилийн тайлан 2023 он

# ДЭЛХИЙ РҮҮ ТЭМҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ БРЭНД



# Санхүүгийн үзүүлэлт

2023 он нь Монложистикс Группийн хувьд тээврийн хэмжээ өмнөх оноос 163%, борлуулалтын орлого 55%-иар тус тус өссөн, цэвэр ашиг 11%-иар буурсан жил болж өнгөрлөө.

Тайлант хугацааны эцэст мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө 25 орчим тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Группийн баримталж буй өсөлтийн стратегийн хөрөнгө оруулалтуудыг бүрэн хийх боломжтойг харуулж байна.

## Нэгтгэсэн орлогын тайлан

Орлого үр дүнгийн тайлан (сая.төг)	2021 (restated)	2022 (restated)	2023	Өсөлт
Борлуулалтын орлого	89,479	136,095	210,361	55%
Борлуулалтын өртөг	(80,816)	(119,548)	(192,253)	
<b>Нийт ашиг</b>	<b>8,662</b>	<b>16,547</b>	<b>18,108</b>	<b>9%</b>
Борлуулалт, Удирдлагын зардал	(3,411)	(6,244)	(8,482)	36%
Бусад орлого	238	1,460	(48)	
Бусад зардал	(339)	(344)	(288)	
<b>Үйл ажиллагааны цэвэр ашиг</b>	<b>8,662</b>	<b>16,547</b>	<b>18,108</b>	<b>-19%</b>
Санхүүгийн орлого (зардал)	2	(385)	295	
<b>Татварын өмнөх цэвэр ашиг (ЕВТ)</b>	<b>5,152</b>	<b>11,034</b>	<b>9,585</b>	<b>-13%</b>
ОАТ-н зардал	(689)	(1,642)	(1,222)	
<b>Цэвэр ашиг</b>	<b>4,463</b>	<b>9,392</b>	<b>8,363</b>	<b>(11%)</b>

## Орлогын тайлан

Монгол улсын тээврийн зах зээлийн өрсөлдөөн 2023 онд улам ширүүсэж буй энэ цаг үед Монложистикс Групп нь ялгаралд илүү төвлөрч, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх алхмуудыг хэрэгжүүллээ. Монложистикс Групп нь ложистикийн зах зээлд геополитикийн тодорхойгүй нөхцөл байдлууд дунд амжилт дүүрэн өнгөрлөө. 2023 онд Монложистикс Группийн тээврийн хэмжээ 2022 оноос 163%-иар, борлуулалтын орлого 55%-иар тус тус өссөн байна. Өнгөрсөн онд салбарын өрсөлдөөн ширүүсэж, далайн тээврийн өртөг буурсан шалтгаануудаар нийт ашгийн хувь буурсан байна. Энэхүү нөлөө нь компанийн цэвэр ашгийн хэмжээ төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй үндсэн шалтгаан болж байна.

Борлуулалтын орлогыг сегмент бүрээр.

Тээврийн тоо хэмжээ (мян.тн)	2021	2022	2023	Эзлэх хувь
Импорт	50.5	111.1	98	9%
Экспорт	-	68.4	157.3	15%
Транзит	264	203.2	768	74%
Дотоод	-	13.2	19	2%
<b>Нийт</b>	<b>314.5</b>	<b>395.8</b>	<b>1,042.30</b>	<b>100%</b>

Борлуулалтын орлого (сая.төг)	2021	2022	2023	эзлэх хувь
Импорт	61,625	102,546	84,286	39%
Экспорт	-	7,122	24,638	11%
Транзит	27,728	21,553	87,942	41%
Дотоод	739	8,383	18,046	8%
<b>Нийт</b>	<b>90,092</b>	<b>139,605</b>	<b>214,912</b>	<b>100%</b>
Тохируулах бичилт	(613)	(3,510)	(4,551)	
<b>Нийт</b>	<b>89,479</b>	<b>136,095</b>	<b>210,361</b>	

Монложистикс Группийн орлогын бүрдэл дараах 3 хэсгээс бүрддэг.

**Тээврийн үнэ:** Тээврийн зах зээлд өртөгт суурилсан үнийн бодлого хэрэгждэг тул зах зээлийн нөхцөл байдал богино хугацаанд шууд нөлөө үзүүлдэг. 2023 оны эхэнд БНХАУ улс хилээ бүрэн чөлөөлснөөр өнгөрсөн 3 жил үүсээд байсан тээврийн хүндрэлтэй нөхцөл байдал хэвийн болж, тээврийн өртөг буурсан, транзит тээврийн хэмжээ группийн орлогод эзлэх хувь өссөн тус тус нөлөөгөөр Группийн нэгж тээврийн дундаж үнэ 2023 онд 1735 ам доллар болж өмнөх оноос 39%-иар буурсан байна.

**Ханш:** 2023 оны ам.долларын ханш оны эхнээс 1% буурсан, мөн түүнчлэн дундаж ханш 3465₮ байсан нь группийн таамаглаж байсан хэмжээнээс бага байна. Энэ нь орлогын 80 орчим хувь нь валют суурьтай байдаг манай Группийн борлуулалтын орлогод ханшийн нөлөө бага байгаа юм.

**Тээврийн хэмжээ:** Тээврийн хэмжээ 1 сая тоннд хүрч өнгөрсөн оноос 163% өссөн байна.

Нийт ашгийн маржин	2021	2022	2023
Импорт	12.5%	11.3%	9.6%
Экспорт		19.4%	6.8%
Транзит	8.9%	12.2%	7.5%
Дотоод	44.5%	11.6%	9.9%
<b>Нийт</b>	<b>9.7%</b>	<b>12.2%</b>	<b>8.6%</b>

**Үйл ажиллагааны зардал:** Группийн стратеги нь өсөлт руу чиглэж буй тул шинэ бизнесийн судалгаа хөгжүүлэлт нэмэгдэж, хүний нөөцийн бодлогын хүрээнд дотоод ажилтнууд руу чиглэсэн бодлогын хэрэгжүүлэлт болон олон нийтэд нээлттэй компани болох зэрэг үйл ажиллагаатай холбоотойгоор тодорхой зардлуудыг нэмэгдүүлсний улмаас үйл ажиллагааны зардал 36%-иар нэмэгдсэн байна.

**Цэвэр ашиг:** 2023 онд Групп нь 8.3 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, өнгөрсөн оноос 11%-иар буурсан байна.

Мөнгөн гүйлгээний тайлангийн үзүүлэлт (сая.₮)	2021	2022	2023
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(5,997)	9,382	4,480
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,129	(1,232)	(2,390)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,420	(492)	6,037
Валютын ханшийн зөрүү	(14)	725	(203)
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(3,462)</b>	<b>8,383</b>	<b>7,924</b>
<b>МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ</b>	<b>9,277</b>	<b>5,816</b>	<b>14,198</b>
<b>МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ</b>	<b>5,816</b>	<b>14,198</b>	<b>22,122</b>

- Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ 4 тэрбум төгрөг
- 2023 оны 9-р сард олон нийтээс 10.9 тэрбум төгрөг татан төвлөрүүлснээс 0.9 тэрбум төгрөгийг зарцуулж, бусад мөнгөн хөрөнгийг төлөвлөж буй хөрөнгө оруулалтад зарцуулах хүртэл хүүтэй эх үүсвэрт байршуулсан байна.
- Бондын үндсэн төлбөр болох 2 тэрбум төгрөгийг хүүгийн хамт төлсөн. Мөн эргэлтийн хөрөнгийн бусад зээлийг бүрэн төлж барагдуулсан.
- Тайлант хугацааны эцэст мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө (мөнгөн хөрөнгө + богино хугацаат хөрөнгө оруулалт) 25 орчим тэрбум төгрөг байна. Группийн баримталж буй стратегийн дагуу ирэх онд томоохон хөрөнгө оруулалтуудыг төлөвлөөд байна.

# Импорт тээвэр

Монложистикс Группийн импортын тээврийн дундаж үнэ 2534 \$ хүрч, өмнөх оноос 13%-иар буурсан нь импортын борлуулалтын орлогыг 18%-иар бууруулсан байна.

Орлого үр дүнгийн тайлан (сая.төг)	2021 (restated)	2022 (restated)	2023	Growth
Тээврийн тоо хэмжээ	50.50 мян.тн	111.09 мян.тн	98.02 мян.тн	
Борлуулалтын орлого	61,625	102,546	84,286	(18%)
Борлуулалтын өртөг	(53,936)	(90,980)	(76,197)	
<b>Нийт ашиг</b>	<b>7,689</b>	<b>11,566</b>	<b>8,089</b>	<b>(30%)</b>
<b>Нийт ашгийн хувь</b>	<b>12.5%</b>	<b>11.3%</b>	<b>9.6%</b>	
Борлуулалт, ерөнхий удирдлагын зардал	(2,993)	(3,738)	(4,764)	
Бусад орлого (зардал)	(112)	(94)	(99)	
Татварын өмнөх ашиг	4,584	7,734	3,226	(58%)
Татварын зардал	(552)	(1,110)	(400)	
Цэвэр ашиг	4,031	6,624	2,826	(57%)
<b>Цэвэр ашгийн хувь</b>	<b>6.5%</b>	<b>6.5%</b>	<b>3.4%</b>	

## Зах зээлийн нөхцөл байдал

Дэлхийн ложистикийн салбарт үүссэн цар тахлын нөлөө бага багаар арилж, далайн тээврийн үнийн өсөлт буурч, хэвийн түвшин рүүгээ ойртож байна. Хэдий тийм боловч Монгол Улс руу тээвэрлэгдэж буй ачаа барааны 80 гаруй хувь БНХАУ-ын Тианжинь боомт болон Замын-Үүд боомтоор дамжин өнгөрдөг ба чингэлэг тээвэр саатах явдал давтагдсаар байна. 2023 оны 1-р сард Эрэнээс Замын-Үүд боомтын авто замын хил нээгдсэнээр нөхцөл байдал сайжирсан. ОХУ нь олон улсын хоригт орсонтой холбоотой Европын холбооны улсуудаас ирэх тээвэр өдөр бүр шинэ сорилтуудтай тулгарч байна.

## Үйл ажиллагааны товч мэдээлэл

2023 онд далайн тээврийн нөхцөл байдал хэвийн болж, БНХАУ-аас ачааг авто замын боомтоор нэвтрүүлэх боломжтой болсноор зах зээл дээр импортын тээврийн суурь үнэ буурсан. Ингэснээр Монложистикс Группийн импортын тээврийн дундаж үнэ 2,534\$ хүрч, өмнөх оноос 13%-иар буурсан. Хилийн хориг саад арилснаар зах зээлийн өрсөлдөөн нэмэгдсэн тул үйлчилгээний чанар, маршрут хөгжүүлэлт болон CRM хөгжүүлэлтэд илүү анхаарч ажилласан. МУ-ын Гадаад валютын албан нөөц нэмэгдсэнээр төгрөгийн ханш чангарч, ханшийн олз буурсан ба И-коммерсийг хөгжүүлэхэд нэмэлт хөрөнгө оруулалт хийсэн. Эдгээрийн үр дүнд төлөвлөж байсан ашгийн хэмжээнд хүрч чадаагүй юм. Үйлчлүүлэгчдийг халамжлах бодлогын хүрээнд Худалдаа хөгжлийн банктэй хамтран зөвхөн Монложистикс Группийн үйлчлүүлэгч нарт зориулан худалдааны санхүүжилтийн үйлчилгээг танилцуулсан. Мөн байнгын үйлчлүүлэгч нарыг дэмжих, шинэ үйлчлүүлэгчийг татах зорилгоор дараа төлбөрт үйлчилгээний аян зарлаж амжилттай хэрэгжүүлсэн юм.

## 2023 оны үр дүн

2023 онд импортын тээврийн зах зээл өмнөх онтой харьцуулахад тээврийн боомтын гацаа, саатал буурсны улмаас тээврийн үнэ буурч, зах зээлийн өрсөлдөөн нэмэгдсэн хэдий ч Монложистикс Групп амжилттай ажиллаа. 2023 онд төгрөгийн ханш чангарч, ОХУ-ын эсрэг хориг зэрэг олон тодорхойгүй нөхцөл байдал дунд өнгөрлөө. Өмнөх оноос 2023 онд борлуулалтын орлого 18%, нийт ашиг 30% тус тус буурсан байна. Тээврийн хэмжээ 11.8% буурч, нэгж тээврийн дундаж үнэ буурсан нь борлуулалтын орлогын гол нөлөө болсон юм. Зах зээлийн өрсөлдөөн нь нэгж тээврийн ашгийн түвшин 9.6% болж буурахад гол нөлөө үзүүллээ.

## 2024 оны хүлээлт

Монгол Улсын төмөр замын вагон хангамж, терминалын дэд бүтцийн хүртээмжгүй байдлаас шалтгаалан Тианжинь, Замын-Үүд боомтуудад ачаа саатаж улмаар Улаанбаатар дахь терминалууд хоосон чингэлгээ буцааж чадахгүй байдал үүсэх магадлалтай. Мөн 2024 онд Монгол улсын эдийн засаг өсөлттэй байх төсөөлөлтэй уялдан импортын хэмжээ нэмэгдэх хүлээлттэй байна. Иймд Монложистикс Групп үйлчлүүлэгчиддээ илүү найдвартай тээврийн маршрут болон тээврийн өртгийг бууруулахад анхаарч, гадаад харилцааг өргөжүүлэх замаар тээврийн үйлчилгээний чанарыг сайжруулах, УБ дахь терминалын хүртээмж хангамжийг нэмэгдүүлэх, E-commerce зах зээлд илүү төвлөрч, Группийн хэмжээнд хуучин машины тээврийг зохион байгуулж эхлэх зэрэг өрсөлдөөнт зах зээл дээр өөрсдийн байрших стратегийг боловсруулан ажиллаж байна.

## ОРЛОГО

84,286 сая.төгрөг

(18%)

## ЦЭВЭР АШИГ

2,826 сая.төгрөг

(57%)



ОРЛОГО

24,638 сая.төгрөг

246%

ЦЭВЭР АШИГ

976 сая.төгрөг

(17%)

# Экспорт тээвэр

Экспортын ачаа тээвэр 157.3 мянган тоннд хүрч борлуулалтын орлого 245.9%, нийт ашиг 20.9%-иар тус тус өссөн. Нийт ашгийн түвшин 6.8% болж буурсан байна.

Орлого үр дүнгийн тайлан (сая.төг)	2021 (restated)	2022 (restated)	2023	Growth
Тээврийн тоо хэмжээ	-	68.37 мян.тн	157.32 мян.тн	
Борлуулалтын орлого	-	7,122	24,638	246%
Борлуулалтын өртөг	-	(5,738)	(22,965)	
<b>Нийт ашиг</b>	-	<b>1,384</b>	<b>1,673</b>	<b>21%</b>
<b>Нийт ашгийн хувь</b>	-	<b>19.4%</b>	<b>6.8%</b>	
Борлуулалт, ерөнхий удирдлагын зардал	-	(154)	(411)	
Бусад орлого (зардал)	-	69	(154)	
Татварын өмнөх ашиг	-	1,299	1,108	(15%)
Татварын зардал	-	(130)	(133)	
Цэвэр ашиг	-	1,169	976	(17%)
<b>Цэвэр ашгийн хувь</b>	-	<b>16.4%</b>	<b>4.0%</b>	

## Зах зээлийн нөхцөл байдал

Монгол улс 2023 онд нийт 78.8 сая.тонн бүтээгдэхүүн экспортод гаргаж, түүхэн амжилт тогтоолоо. Үүнд нүүрс 69.6 сая.тонн, төмрийн хүдэр 5.7 сая.тонн, зэсийн баяжмал 1.5 сая.тонн, жонш 1 сая.тонн, цайр 0.2 сая.тонн түүхий эд багтаж байна. Мөн 2022 онд БНХАУ-ын импортоор авч буй коксжих нүүрсний 26 хувийг Монгол улс нийлүүлж байсан бол 2023 онд 46.2 хувийг нийлүүлснээр манай улс хамгийн том нийлүүлэгч болсон байна.

## Үйл ажиллагааны товч мэдээлэл

Монложистикс Группийн хувьд 2023 онд нийт 78.8 сая тонн ачаа бүтээгдэхүүн экспортод гаргаж, түүхэн амжилт тогтоолоо. Үүний 85 хувь нь авто замаар, төмөр замаар 15% тээвэрлэгдсэн. Шинээр ашиглалтанд орсон төмөр замаар 0.8 сая тн буюу маш бага экспорт хийгдсэн байна. 2023 онд экспортыг задалж харвал нүүрс 69.6 сая.тонн, төмрийн хүдэр 5.7 сая.тонн, зэсийн баяжмал 1.5 сая тонн, жонш 1 сая тонн, цайр 0.2 сая тонн түүхий эд багтаж байна. Мөн 2022 онд БНХАУ-ын импортоор авч буй коксжих нүүрсний 26 хувийг Монгол улс нийлүүлж байсан бол 2023 онд 46.2 хувийг нийлүүлснээр манай улс хамгийн том тоглогч болсон байна.

## 2023 оны үр дүн

Монложистикс Группийн экспортын ачаа тээвэр өмнөх мөн оны үеэс 130.1% өсөж, 157.3 мянган тоннд хүрч, борлуулалтын орлого 245.9% өсөж, нийт ашиг 20.9% тус тус өссөн байна. Монложистикс Группийн хувьд экспортын салбарт голчлон төмөр замаар ачаа тээвэрлэдэг бөгөөд Монгол улсад ашиглалтад орсон шинэ төмөр замуудын хил холболт хийгдээгүй, төлөвлөсөн хугацаанаасаа хоцорч ашиглалтад орсон, шинээр ашиглалтад орсон төмөр замуудаас УБТЗ-аар дамжин экспортын тээвэр хийх боломжгүй болж, төмөр замын тээврийн шинэчилсэн хууль 2025 оноос хэрэгжиж эхлэх болсон нь төмөр замууд харилцан галт тэрэг солилцох, хөдлөх бүрэлдэхүүний хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлээгүй байгаа зэрэг нь Монложистикс Группийн экспортын тээврийн төлөвлөгөөт ашигтаа хүрээгүйн гол шалтгаануудын нэг юм.

## 2024 оны хүлээлт

2023 онд Монгол улсын экспорт 15.2 тэрбум ам.долларт хүрч 21%-иар өссөн бол цаашид тус өсөлт хадгалагдах хүлээлттэй байна. Мөн Монгол улсаас экспортолж буй голлох уул уурхайн бүтээгдэхүүний зах зээл дэх үнэ тогтвортой байх төлөвтэй байгаа тул Монложистикс Группийн хувьд экспортын тээврийн салбарт өөрийн хөдлөх бүрэлдэхүүний баазыг нэмэгдүүлэх байдлаар зах зээл дэх өрсөлдөх чадвараа өсгөхөөр зорин ажиллаж байна.

# Транзит ТЭЭВЭР

2023 онд транзит тээврийн орлого өмнөх оноос 308%, цэвэр ашиг 172%-иар тус тус өссөн байна.

Орлого үр дүнгийн тайлан (сая.төг)	2021 (restated)	2022 (restated)	2023	Growth
Тээврийн тоо хэмжээ	264.05 мян.тн	203.17 мян.тн	767.96 мян.тн	
Борлуулалтын орлого	27,728	21,553	87,942	308%
Борлуулалтын өртөг	(25,247)	(18,914)	(81,353)	
<b>Нийт ашиг</b>	<b>2,481</b>	<b>2,639</b>	<b>6,588</b>	<b>150%</b>
<b>Нийт ашгийн хувь</b>	<b>8.9%</b>	<b>12.2%</b>	<b>7.5%</b>	
Борлуулалт, ерөнхий удирдлагын зардал	(1,352)	(1,171)	(1,476)	
Бусад орлого (зардал)	29	470	185	
Татварын өмнөх ашиг	1,158	1,938	5,297	173%
Татварын зардал	(129)	(189)	(532)	
Цэвэр ашиг	1,029	1,749	4,765	172%
<b>Цэвэр ашгийн хувь</b>	<b>3.7%</b>	<b>8.1%</b>	<b>5.4%</b>	

## Зах зээлийн нөхцөл байдал

Дэлхийн геополитикийн нөхцөл байдлаас шалтгаалан ОХУ болон БНХАУ хоорондын худалдаа сүүлийн 2 жилд 64%-иар өсөж, 2023 онд хоёр улсын худалдааны хэмжээ 240 тэрбум ам.долларт хүрсэн байна. Хоёр улсын хооронд тээвэрлэгдэж буй ачаа тээврийн 17 орчим хувь нь буюу 2023 онд 5.1 сая.тонн ачаа Монгол улсаар дамжин өнгөрсөн. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 61% өссөн үзүүлэлт юм.

## Үйл ажиллагааны товч мэдээлэл

Монложистикс Групп нь төмөр замын транзит тээвэрт голчлон анхаарч үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тус зах зээлийн 24%-ийг дангаараа эзэлж байна. 2023 онд шинэ харилцагчидтай хамтран ажиллаж эхэлснээр тээврийн хэмжээ өнгөрсөн оноос 278%-иар өсөлт үзүүлсэн байна.

## 2023 оны үр дүн

2023 онд борлуулалтын орлого өмнөх оноос 308.0%, нийт ашиг 149.7% тус тус өссөн байна. Ачааны тоо хэмжээ өссөнөөс шалтгаалан Замын-Үүд боомтод түгжрэх, удаашрах гэсэн шалтгаануудаас үүдэн нэмэлт зардлууд үүсэж, нийт ашгийн хувь 7.5 болж өмнөх оноос буурсан байна. Үйл ажиллагааны зардал борлуулалтын өсөлтөөс бага хувиар өссөн нь өнгөрсөн оноос үйл ажиллагааны ашиг 173.3%-иар өсөхөд хүргэсэн байна.

## 2024 оны хүлээлт

2023 байдлаар борлуулалтын орлого цөөн харилцагчдаас өндөр хамааралтай байна. Иймд Монложистикс Групп нь урт хугацааны тогтвортой хөгжлийг бий болгохын тулд үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, үйлчлүүлэгчдийн тоог өсгөхөөр төлөвлөн ажиллаж байна. 2024 онд хөрш хоёр улсын худалдааны эргэлт улам өсөх төлөвтэй байгаа болон Монгол улсын “Алсын хараа 2050” төлөвлөгөөнд багтсан төмөр замын сүлжээний зүүн коридорыг барьж байгуулах төсөл 2024 онд эхлэх төлөвлөгөөтэй байгаа зэрэг нь Монгол улсын транзит тээврийн зах зээл цаашид өсөх хүлээлтийг бий болгож байна.

ОРЛОГО

87,942 сая.төгрөг

**308%**

ЦЭВЭР АШИГ

4,765 сая.төгрөг

**172%**



орлого

18,046 сая.төгрөг

115%

ЦЭВЭР АШИГ

654 сая.төгрөг

15%

# Бусад тээвэр

2023 онд борлуулалтын орлого 115%,  
цэвэр ашиг 14.8% тус тус өссөн байна.

Орлого үр дүнгийн тайлан (сая.төг)	2021 (restated)	2022 (restated)	2023	Growth
Тээврийн тоо хэмжээ	-	13.21 мян.тн	19.03 мян.тн	
Борлуулалтын орлого	739	8,383	18,046	115%
Борлуулалтын өртөг	(410)	(7,408)	(16,267)	
<b>Нийт ашиг</b>	<b>329</b>	<b>976</b>	<b>1,778</b>	<b>82%</b>
<b>Нийт ашгийн хувь</b>	<b>44.5%</b>	<b>11.6%</b>	<b>9.9%</b>	
Борлуулалт, ерөнхий удирдлагын зардал	(335)	(474)	(719)	
Бусад орлого (зардал)	(33)	146	(261)	
Татварын өмнөх ашиг	(39)	648	798	23%
Татварын зардал	(0)	(78)	(145)	
Цэвэр ашиг	(39)	569	654	15%
<b>Цэвэр ашгийн хувь</b>	<b>-5.3%</b>	<b>6.8%</b>	<b>3.6%</b>	

## Зах зээлийн нөхцөл байдал

**Гадаад:** Орос-Европын худалдааны урсгалын өөрчлөлтөөс шалтгаалан нийлүүлэлтийн сүлжээ эрс өөрчлөгдөж өмнө нь Европ руу явж байсан ачааны урсгал одоо Алс Дорнод руу чиглэсэн байна. Олон улсын ложистикийн компаниуд ОХУ-тай хамтын ажиллагаагаа зогсоох шаардлагатай болж, Улмаар Maersk, DHL, UPS, FedEx, MSC, CMA CGM гэх мэт далайн тээврийн компаниуд ОХУ-ын зах зээлээс гарч, тэдний орон зайг ОХУ болон БНХАУ-ын тээврийн компаниуд гүйцэтгэж байна.

**Дотоод:** 2023 онд цар тахлын дараах ачаа урсгал бүх төрөлд нэмэгдэж нийт тээвэрлэсэн ачааны хэмжээ 71.3 сая.тонн болж 2.1 дахин өссөн нь авто тээврийн салбарын орлого өсөхөд голлон нөлөөлжээ. Авто тээврийн орлого хамгийн өндөр дүнгээр өсөхөд экспорт, импортын өсөлт нөлөөлсөн бөгөөд 2023 онд экспортын ачааны 86%, импортын ачааны 45.3%-ийг авто тээвэр эзэлж байна.

## Үйл ажиллагааны товч мэдээлэл

Монложистикс Группийн гадаад улс дахь тээврийн үйл ажиллагааны цар хүрээ улам өргөжин тэлж, БНХАУ-ОХУ хооронд ОХУ-ын Владивосток, Забайкальск боомтуудаар дамжуулан шууд тээвэрлэлт гүйцэтгэж, тогтмол тээвэр зохион байгуулсан. Мөн Монгол улсын нутгаар дамжуулан олон улсын TIR конвенцийн дагуу гаалийн баталгаат тээвэрлэлтээр жирийн, температурын тохируулгатай, овор хэмжээ хэтэрсэн гэх мэт төрөл бүрийн авто замын транзит ачаа тээврийг амжилттай гүйцэтгэсэн байна.

## 2023 оны үр дүн

2023 онд БНХАУ авто замын боомтоо нээснээр хөрш орнуудын хооронд худалдаа, бараа эргэлтийн хэмжээ нэмэгдэж, улмаар Монгол улсаар дамжин өнгөрөх авто тээврийн ачааны хэмжээ шууд нэмэгдсэн юм. Бүс нутгийн зах зээлийн энэхүү өсөлт Монложистикс Группийн үйл ажиллагаанд эергээр нөлөөлсөн бөгөөд 2023 онд борлуулалтын орлого 115.3%, нийт ашиг 82.2%, цэвэр ашиг 14.8% тус тус өссөн байна.

## 2024 оны хүлээлт


БНХАУ болон ОХУ хоорондын ачаа тээврийн өсөлт үргэлжилж, ОХУ-ын эсрэг авч буй хориг арга хэмжээ улам нэмэгдэж байгаа нь ложистикийн салбарт цаашид таамаглашгүй нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй байна. Монгол улсын ачаа тээврийн хэмжээ нь засгийн газрын хэрэгжүүлж буй Боомтын сэргэлтийн бодлогын хүрээнд эдийн засгийн хүлээгдэж буй өсөлтөөс давж өсөх төлөвтэй байна. Иймд Монложистикс Групп нь 2024 онд авто тээвэр болон хөдлөх бүрэлдэхүүн (вагон)-д хөрөнгө оруулж, тус сегментэд үйл ажиллагаагаа улам тэлэх зорилт тавин ажиллаж байна.

# 04

## Тогтвортой ХӨГЖИЛ

---

Үйл ажиллагааны жилийн тайлан 2023 он



# ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

## НИЙГЭМ БА БАЙГАЛЬ ОРЧИН

Бид тогтвортой хөгжлийн суурь стратегиа бататгах хүрээнд нийгэм ба байгаль орчинд ээлтэй байж, компанийн засаглалыг сайжруулах төсөл хөтөлбөрүүдийг 2023 онд шинээр эхлүүллээ. Байгаль орчин, нийгэм, засаглалын хүрээнд бидний авч хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд хэдийгээр урт хугацааг туулаагүй байгаа хэдий ч, ирээдүйд нийгэм, эдийн засаг, салбарын хөгжилд томоохон нөлөө бий болгоно гэдэгт итгэл дүүрэн ажиллаж байна.

Нийгмийн хариуцлагын хүрээнд бид Монгол улсын ирээдүй болсон залуу үед өндөр үнэ цэн өгөх төсөл хөтөлбөрийг сонгон авч хэрэгжүүлэхийг зорьдог бөгөөд нэн тэргүүнд нийгэмд сайн дураараа үйл ажиллагаа явуулж, түүгээрээ дамжуулан өөр өөрсдийн онцлог бүхий орон зайд шинэ санал санаачилга, инновацыг нэвтрүүлж байгаа залуусаас эхэлсэн юм.







## ШАМБАЛА 2056

Бид 2022 онд 500ш хайлаас мод тарьж нийслэлийн байгаль орчны газар болон хариуцах байгууллагад хүлээлгэж өгч байсан бол 2023 онд цөлжилтийн эсрэг нэн шаардлагатай мод тарих газрыг сонгож, үүний хүрээнд “Shambala 2056” төслийг хэрэгжүүлэгч мэргэжлийн байгууллагатай хамтарч ажиллах шийдэлд хүрсэн юм.

Шамбала инженеринг кампус нь Дорноговь аймгийн Эрдэнэ сум, Төхөмийн хөндий, Ар цацын ус гэдэг газарт үйл ажиллагаагаа явуулж байна. Уг төслийн зорилго нь 2016 оноос 2056 он хүртэл 40 жилийн хугацаанд Дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилтуудын хүрээнд хуурай газрын экосистемийн урт хугацаанд хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг урлаг, технологи ашиглан бууруулахаар зорьж буй төсөл юм.



Монложистикс Групп 2023 оны 5 дугаар сард “Shambala 2056” Art’N Tech Land Art төслийг ивээн тэтгэж хамтын ажиллагааны гэрээ байгуулсан. Монложистикс Групп нь энэ төслийг дэмжин хамтарч ажилласнаар дараах үр нөлөөг байгаль, экологид бодитоор үзүүлж, холбогдох батламжийг гардаж авсан юм. Үүнд:

1. “CO2 Нүүрс хүчлийн 220,309.09кг давхар ислийг боловсруулсан.
2. O2 367,181.8кг хүчилтөрөгч ялгаруулсан.
3. 1,255,871.2кг биомасс үүсгэсэн.



## ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭР

Монложистикс Групп нь уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн бага нөлөөтэй төмөр замын тээврээр уул уурхайн бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд анхаарч, энэ чиглэлд голлон ажиллаж байна. EcoTransIT World дээр жишээ болгон Улаанбаатар хотоос БНХАУ-ын Эрээн боомт хүртэл 100 ширхэг 20 футийн чингэлэг буюу 1 цуваа вагоноор ачаа тээвэрлэхэд ялгаруулах хүлэмжийн хийн хэмжээг авто тээвэртэй харьцуулан үзэхэд энэхүү тооцооллоор авто зам нь төмөр замаас 50%-иар илүү хүлэмжийн хийг ялгаруулж байдгийг баталж байна.


### GHG emissions (calculated as CO2 equivalents)

#### WTW [Tonnes]

	TSTruck	TSTrain
Truck	42	0
Train	0	21
<b>Sum</b>	<b>42</b>	<b>21</b>

#### TTW [Tonnes]

	TSTruck	TSTrain
Truck	35	0
Train	0	18
<b>Sum</b>	<b>35</b>	<b>18</b>



Эх сурвалж: EcoTransIT World

Монложистикс Группийн охин компани болох Каус Аустралис ХХК 2023 онд нийт 16000 тонн ачааг төмөр замаар тээвэрлэсэн нь байгаль орчинд ээлтэй байхын төлөө, хүлэмжийн хийн ялгарлыг өөрсдийн үйл ажиллагааны хүрээнд багасгаж байгаа нэг том хэлбэр юм. Цаашид Монложистикс Групп Монгол улсын уул уурхайн экспортын тээврийг байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл хамгийн багатай тээврийн төрөл болох төмөр замын тээвэрт илүү анхаарч өөрийн эзэмшлийн тээврийн хөдлөх бүрэлдэхүүн болох вагон худалдан авахаар төлөвлөн, нийт 7,3 сая ам доллар буюу 25 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр урт хугацаанд төлөвлөн ажиллаж байна.



## DO GOOD HUB

Монложистикс Групп нь “Лантуун дохио” ТББ-ын Үүсгэн байгуулагч Ч.Ганжавхлантай хамтран залуучуудын оролцоог дэмжих, дуу хоолойг нийгэмд хүргэх, залуучуудын сайн дурын үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилготой “Do Good Hub” төвийг 2023 оны 09 сарын 08-ны өдөр албан ёсоор нээж үйл ажиллагааг эхлүүлсэн. Уг төвийг Монложистикс Групп 100% санхүүжүүлж, залуучуудын нийгмийн оролцоонд илүү тодоор нөлөөлөх зорилгод бодитой хөрөнгө оруулалт хийсэн юм.



### Бидний сонгон шалгаруулж, дэмжин ажиллаж буй ТББ-ын танилцуулга

Манай төв нь 2023 оны 9-р сараас үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд албан ёсны сонгон шалгаруулалт явуулж, 15 байгууллагатай 1 жилийн хугацаатай хамтран ажиллах гэрээ байгуулан, олон төрөлт үйл ажиллагааг амжилттай дэмжин хэрэгжүүлж байна. Идэвхтэй үйл ажиллагаатай хамтран ажиллаж буй зарим байгууллагуудыг танилцуулахад:



#### Тогтвортой хөгжлийн жигүүр

НҮТББ- (иргэдийн нийгмийн оролцоо болон хөгжлийн хүрээнд төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэх зорилготой)

- Монгол Оюун ба Шатар төслийн хүрээнд шатрын анхан, дунд шатны багш нарыг бэлдэж, шатрын спортыг олон нийтэд сурталчлах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.



#### Цэцээ гүн Ротаракт клуб

Боловсрол болон эрүүл мэндийн чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлдэг.

- 11 дэх жилдээ зохион байгуулагдаж буй хүн бүр сурах эрхтэй зорилгын хүрээнд менторшип болон тэтгэлэг хосолсон төслийг амжилттай хэрэгжүүлсэн.



#### Монгол туургатан хэл хуурын нийгэмлэг

Урлаг, өв соёлоо залуу үедээ өвлүүлэн үлдээх зорилготой

- Нүүдэлчдийн хэмнэл хэл хуур, Олон улсын хэл хуурын өдрүүдийг Монголд анх тэмдэглэх ажлыг зохион байгуулж, нийт 77 хүнд 2 өдрийн сургалтыг Дэлхийн шилдэг хэл хуурч С.С.Шишигин, Монголын ахмад хэл хуурч өв тээгч Б.Хүүхэндүү, якут урлаач хуурч Иннокентий Уран, Монгол хэл хуурын төвийн багш Б.Батням нар удирдан явуулсан.



#### Еннеаграм Монгол Шийдэл ТББ

Хүний зан чанарыг оношлон, өөрийгөө танин мэдэхэд туслах сургалтуудыг зохион байгуулдаг

- “Нийгэмд тодоор нөлөөлө” уриалгын хүрээнд хийгдэж буй “Ээжүүдийн сэтгэлзүй” сургалтыг зохион байгуулсан. Сургалтад сонирхсон ээжүүд оролцож өөрийгөө таньж мэдэх, стрессээ тодорхойлох, тайлах мөн сэтгэлзүйн боловсрол, эрүүл мэндийн тухай эмэгтэйчүүдэд хэрэгтэй сэдвээр сургалт хөгжлийн ажлыг хийж ажилласан.

#### Менторуудын чиглүүлэх сургалтууд

Манай төвийн удирдах зөвлөлийн гишүүд, менторууд хамтрагч байгууллагууддаа шаардлагатай сургалтуудыг цаг тухайд нь орж, зөвлөн чиглүүлж ажилласаар байна. Мөн нийгэмд болж буй бүхий л асуудлууд дээр чимээгүй өнгөрөх биш дуу хоолойгоо илэрхийлж, хамтдаа сэтгэлгээг хөгжүүлэхийн тулд уриалан ажиллалаа.

## ESOP ХУРИМТЛАЛЫН ХӨТӨЛБӨР

Ажилтан ажил олгогчийн хамтарсан хуримтлалын хөтөлбөр нь тэтгэврийн болон бусад урт хугацааны санхүүгийн зорилгоор ажилтан ажил олгогчтойгоо хамтран бий болгох тогтмол хуримтлалыг тэдний шууд оролцоо, хяналтын дор мэргэжлийн хөрөнгө оруулалтын компани (ХОМК) удирдан өсгөж, үр өгөөж бий болгосноор ажилтны ирээдүйн санхүүгийн баталгааг сайжруулдаг олон улсад тогтсон жишиг загвар юм.

Монложистикс Ирээдүй сан нь үндсэн зорилгынхоо хүрээнд дараах зорилтуудыг тавьж ажиллаж байна. Үүнд:



Ажилтнаа урамшуулах, тэдгээрийн санхүүгийн чадварыг нэмэгдүүлэх, ирээдүйн санхүүгийн баталгааг хангах



Үр ашигтай, олон улсын жишигт нийцсэн, хуулийн хүрээн дэх ажилтны хамтарсан хуримтлалын санг бий болгох



Тогтвортой хүний нөөцийг цогцлоох



Ажилтан болон ажил олгогчийн хамтын зорилгыг бий болгох



### 5% + 5%

#### Хуримтлуулах хувь

Ажилтан сар бүр өөрийн нэрлэсэн цалингийн 5 хувийг хуримтлуулах ба ижил дүнг ажил олгогчоос нэмж хуримтлуулна.

#### Хуримтлалын жилийн

### 16%

Зорилтот өгөөж

#### Хуримтлалд нэгдсэн

### 46%

Ажилтны хувь



#### Хуримтлалын хяналт

- Ажилтны хяналт (аппликэйшн)
- Ажил олгогчийн хяналт
- Кастодиан банкны хяналт
- СЗХорооны хяналт
- Хөндлөнгийн хяналт




#### Хуримтлалын удирдлага

Сангийн хөрөнгийг Ашид Ассет Менежмент ХОМК удирдана.

# ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

Монложистикс Группийн Хүний нөөцийн нэгж үндсэн 4 стратегийг баримтлан ажилладаг бөгөөд энэхүү стратеги чиглэлийн хүрээнд 2023 онд доорх ажлуудыг зохион байгуулж ажиллаа.

Нийт ажилтнуудын тоо: **180**



## 1. Өрсөлдөхүйц цалин хөлс, хөнгөлөлт хангамж

Монложистикс групп нь зах зээлийн цалингийн судалгаанд үндэслэн Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлд болон салбарт өрсөлдөхүйц цалингийн сүлжээг баримтлан ажилладаг. Бид 2023 оноос эхлэн 1 жилийн ойн бонус хөтөлбөрөө эхлүүлж, ажилд орсон цагаасаа өөрийн үнэт 1 жилийн хугацааг Монложистикс Группт бүтээмж дүүрэн зориулсан хүн бүрд энэхүү урамшуулалт цалинг олгож байгаа юм.

2023 оны 1-р сараас эхлэн ажилласан жилээс хамаарсан “Ажилласан жилийн нэмэгдэл цалинг” үндсэн цалин дээр 2,4,6-аас дээш жилд тус тус үнэлж, нэмж олгох болсон. Ажилтны нийгмийн асуудлыг шийдэх үүднээс 3 сарын цалинтай тэнцэх хүүгүй цалингийн урьдчилгааг 1 жилийн хугацаатай олгодог болсноор нийт ажилтны 65% нь хамрагдаж өрхийн, өөрийн, боловсрол, эрүүл мэнд, амралт зугаалга, нийгмийн асуудлаа хүндрэлгүй шийдээд байна.

## 2. Ажлын уян хатан цаг, тав тухтай орчин

2022 онд ажлын уян цаг 1 цаг байсан бол 2023 оноос эхлэн 2 цаг болсон. Ажилдаа ирэх цаг 07:30-09:30, явах цаг 16:30-18:30 болсон нь ажилтан бүр ямар ч хол зайнаас ажилдаа саадгүй ирэх боломжтой болсон ба өглөө эрт ирж, орой эрт тарж түгжрэлийн цагаар өөртөө болон гэр бүлдээ зарцуулах цагийг шийдэж өгсөн алхам болсон юм. Уг шийдвэр гарснаас хойш Группийн ажилтнуудын дундаж хоцролт 80% буурч, ажлын бүтээмж 20% нэмэгдсэн судалгаа байна.



Гэрэл зургийг: Unread.today

## 3. Ажилтан болон гэр бүлд нь ээлтэй байгууллага

### Байгууллагын сэтгэл зүйч

Ажилтны сэтгэлзүйн эрүүл мэндийг дэмжих зорилгоор Family College-ийн Ц.Дэлгэрмэнд сэтгэл зүйчтэй хамтран ажилтан хүссэн үедээ байгууллагын зардлаар “Ганцаарчилсан сэтгэлзүйн зөвлөгөө” авах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн юм. Уг хөтөлбөрийн хүрээнд байгууллагын нийт ажилтнуудаас 12% нь тогтмол ганцаарчилсан зөвлөгөө авч, ажлын стресст өртөхөөс сэргийлж, өөрт болон өөрийн гэр бүлдээ хэрэгтэй зөвлөгөө мэдээллийг авч хэрэгжүүлсээр байна.



### Зайнаас ажилладаг ээж

Монложистикс Групп нь 2023 онд жирэмсэн болон хүүхэд асрах чөлөөтэй ээжүүдийг дэмжих зорилгоор ажилтны хүсэлтийг харгалзан үзэж, байнга зайнаас ажиллуулж, компанийн зорилго биелэхэд ээжүүд хувь нэмрээ оруулсаар байна. Энэхүү дотоод зохицуулалт нь ажилтны гэртээ хүүхдээ харах үеийн орлогыг тогтвортой байлгаж, карьерын зогсонги байдал үүсэхгүйгээр гэрээсээ тайван ажиллаж, бяцхан үрсээ эрүүл аюулгүй өсгөх боломжоор хангаж байгаа том дэмжлэг болж чадсан юм.



### 4. Бусдыг хүчирхэгжүүлэх манлайллын соёл

Группийн Гүйцэтгэх захирлын санаачилгаар Монложистикс Холдинг ХК-ийн Гүйцэтгэх удирдлагын баг Монгол улсын гавьяат тамирчин Б.Гангамаатай хамтран Монгол Алтайн нурууны хамгийн өндөр уул болох Алтай Таван Богдын хамгийн өндөр цэг “Хүйтэн Оргил” /4374м/-д багаараа 100% амжилттай авирч, Монложистикс Группийн тугийг нэр төртэй мандуулсан юм.



Бид Группийн сургалт хөгжлийн бодлогын дагуу удирдлагын шатны залгамж халааг бэлдэх зорилгоор жил бүр Азийн №1 сургууль болох Сингапурын Үндэсний их сургуультай хамтран манлайллын хөтөлбөрт шилдэг менежер, захирлуудыг 3 дахь жилдээ амжилттай хамрууллаа.



2023 оны 9-р сараас эхлэн СЭЗИС-ийн ахисан түвшний бизнесийн сургуультай хамтран “Манлайлал” хөтөлбөрийн хичээлийг манай сургагч багш нар мэргэжлийн түвшинд боловсруулан гаргаж, боловсролын яаманд бүртгэлжүүллээ. Уг хөтөлбөрт Монложистикс Групп өсөх ирээдүйтэй ажилтнуудаа сонгон шалгаруулж, 50% хөнгөлөлттэй 1-1.5 жилийн хугацаатай Магистрын хөтөлбөрт хамрууллаа.





# 05

## Засаглал

---

Үйл ажиллагааны жилийн тайлан 2023 он

## ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ

Оноосон нэр:

**Монложистикс Холдинг ХК**

Хэлбэр:

**Нээлттэй хувьцаат компани**

Регистрийн дугаар:

**6381251**

Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага:

**Монголын Хөрөнгийн бирж**

МХБ-ийн хувьцааны бүртгэлийн ангилал:

**II**

Гаргасан нийт хувьцааны тоо ширхэг:

**395,858,822**

Бизнесийн үндсэн үйл ажиллагааны салбар:

**Тээвэр ложистик, Менежментийн зөвлөх үйлчилгээ**


## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ:

**Хувьцаа эзэмшигчдийн тоо:**

2023.09 **1307 IPO**

2023.12 **1344**

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц:



- 15.0% ■ Олон нийт
- 1.8% ■ Мандал Праявит Экүйти ХОС ХХК
- 3.8% ■ Н.Эрдэнэбилэг
- 3.8% ■ Н.Алтанзул
- 3.8% ■ Л.Эрдэнэсоёл
- 8.0% ■ А.Одгэрэл
- 8.0% ■ Г.Хишигбат
- 27.9% ■ Б.Тэлэнгэд
- 27.9% ■ Л.Ганзоригт

# ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хувьцаа эзэмшигчдийн хурлын бусад үед Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн эрх барих дээд удирдлага юм. Монложистикс Холдинг ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь ердийн 5 гишүүн, хараат бус 4 гишүүн, нийт 9 гишүүнтэй олон улсын засаглалын кодексийн дагуу ажиллаж байна.

## ТУЗ-ИЙН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

ТУЗ нь Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон Компанийн дотоод дүрэм журамд заасан Монложистикс Холдинг ХК-ийн ТУЗ-ийн болон охин компаниудын хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх, үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлэн ажилладаг.

ТУЗ нь 2023 онд биечлэн, цахимаар, биечлэн болон цахим хосолсон, эчнээ санал хураалтын хэлбэрээр нийт 14 удаа, 86% ба түүнээс дээш хувийн ирцтэй хуралдаж, 39 тогтоол шийдвэр гаргасан.

## ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

Компанийн ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар явуулах зорилготой. Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо, Аудит, эрсдэлийн удирдлагын хороо, Стратеги, бизнес хөгжлийн хороо гэсэн 3 хороодтой. ТУЗ-ийн дэргэдэх хороод нь Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, хороодын үйл ажиллагааны журамд заасан эрх, үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

## ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ЦАЛИН, УРАМШУУЛАЛ ТООЦОХ ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Гүйцэтгэх захирлын цалин, урамшуулал нь ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан үндсэн цалин болон богино хугацааны урамшууллаас бүрдэнэ. Тайлант онд Гүйцэтгэх захирлын үндсэн цалинд өөрчлөлт ороогүй. Дараах гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн дагуу урамшуулал олгодог. Үүнд:

Үндсэн үзүүлэлт	Хэмжүүр	Зорилтот үр дүн	Эзлэх жин
Ашигт ажиллагаа	Төсвийн гүйцэтгэл	Санхүүгийн тайлан	Төлөвлөгөөний хүрээнд байх
	Цэвэр ашиг	Санхүүгийн тайлан	Гүйцэтгэл >= 100% Төлөвлөгөө
	Авлагын түвшин	Санхүүгийн тайлан	Хугацаа хэтэрсэн авлага <= 30% нийт авлага
Стратегийн ажлууд OGSМ	Стратеги гүйцэтгэл	OGSM тайлан	Гүйцэтгэл >= 80% Төлөвлөгөө
	Customer Satisfaction Index	Annual survey	Above 85%
	IR төлөвлөгөөний биелэлт	Annual report	Above 95%
	Employee Satisfaction Index	Annual OCS survey	Above 80%

2023 онд Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо 2 удаа, Аудит, эрсдэлийн удирдлагын хороо 2 удаа хуралдаж, 2 удаагийн ажлын уулзалт хийсэн. Стратеги, бизнес хөгжлийн хороо 1 удаа хуралдаж, хороодын чиг үүргийн хүрээнд хэлэлцсэн асуудлын талаар дүгнэлт, зөвлөмж гаргасан.

ТУЗ-ийн шинээр томилогдсон гишүүдэд Чиглүүлэх сургалтыг зохион байгуулж Группийн үйл ажиллагаатай танилцуулдаг. Мөн Аудит эрсдэлийн хорооноос Дотоод аудиртой хамтран Группийн удирдлагын багт Дотоод аудит, хяналтын тогтолцооны талаарх сургалт орсон.

## ТУЗ-ИЙН ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

Компанийн ТУЗ-ийн цалин болон үйл ажиллагааны төсвийг 2023 оны 11-р сарын 18-ний өдөр хуралдсан ХЭХ-аас дараах байдлаар тогтоосон бөгөөд уг батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулан, нэмэлтээр шагнал, нөхөн олговор, бусад урамшуулал олгоогүй болно.

Зардлын төсөв	Нийт зардал /₮/
Цалингийн зардал:	
- ТУЗ-ийн дарга	
- ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүд	197,723,902 ₮
- ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	
- ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитор	

Компанийн ТУЗ-ийн цалин болон үйл ажиллагааны төсвийг 2024 оны 4-р сарын 27-ны өдөр хуралдах ХЭХ-р хэлэлцүүлж, батлуулахаар төлөвлөж байна.



# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ, ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ

## Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт

Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх нь засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг нэвтрүүлэх замаар хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах, итгэлцлийг бий болгох, компанийг эрсдэлээс хамгаалж, тогтвортой үнэ цэнийг бүтээх чухал ач холбогдолтой учир шинээр томилогдсон Төлөөлөн удирдах зөвлөлөөс Хувьцаат компани болж, компанийн дүрэм болон засаглалын бодлогын бичиг баримтуудад өөрчлөлт орох шаардлагын дагуу засаглалын дүрэм журмуудыг Компанийн засаглалын кодекс, зохицуулагч байгууллагуудын дүрэм журамд нийцүүлэн шинэчлэн батлахад анхаарч ажиллалаа.

## Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн өөрийн үнэлгээ

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12	100%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	9	90%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6	100%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6	100%
5	Эрсдэлийн удирдлага	8	7	87%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6	100%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8	100%
8	Компанийн соёл	6	5	83%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10	100%
Нэгдсэн дүн:		72	69	95%

Монложистикс Холдинг ХК нь Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн өөрийн үнэлгээг анх удаа хийж, санхүүгийн зохицуулах хороонд хүргэсэн. Компани засаглалын кодексийн үнэлгээгээр 95% буюу

засаглал хэвийн, эрсдэлгүй гэж дүгнэгдсэн бөгөөд 2024 онд засаглалын бодлогын баримт бичгүүдийг мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллахад анхаарна. Компанийн засаглалын зэрэглэл нь хэвийн, эрсдэлгүй байх нь компанийн хөрөнгө оруулагч, бусад оролцогч талуудын шийдвэр гаргалтад эергээр нөлөөлөх чухал ач холбогдолтой.

## Засаглалын бодлого, журам

	Баримт бичгийн нэр	Батлах хэлбэр	Хэрэгжүүлэлт
<b>A</b>	<b>Дүрэм, бодлогын баримт бичиг, заавар болон бусад:</b>		
1	Бизнесийн ёс зүйн дүрэм	Өмнө батлагдсан	Шинэчлэхээр ажиллаж байна
2	Залгамж халааны бодлого	Шинээр баталсан	Хэрэгжилтийг ханган ажиллаж байна
3	Цалин, урамшууллын бодлого	Өмнө батлагдсан	Хэрэгжилтийг ханган ажиллаж байна
4	Ногдол ашгийн бодлого	Шинээр баталсан	Хэрэгжилтийг ханган ажиллаж байна
5	Эрсдэлийн удирдлагын бодлого	Шинээр баталсан	Хэрэгжилтийг ханган ажиллаж байна
6	Дотоод аудитын бодлого	Шинээр баталсан	Хэрэгжилтийг ханган ажиллаж байна
7	Дотоод хяналтын бодлого	Шинээр баталсан	Хэрэгжилтийг ханган ажиллаж байна
8	Комплайнсын хяналт бодлого	Шинээр баталсан	Хэрэгжилтийг ханган ажиллаж байна
<b>B</b>	<b>Дотоод дүрэм журам</b>		
1	Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журам	Шинээр баталсан	Хэрэгжилтийг ханган ажиллаж байна
2	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журам	Шинээр баталсан	Хэрэгжилтийг ханган ажиллаж байна
3	ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны журам	Шинээр баталсан	Хэрэгжилтийг ханган ажиллаж байна
4	Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам	Өмнө батлагдсан	Хэрэгжилтийг ханган ажиллаж байна
5	Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам	Шинээр баталсан	Хэрэгжилтийг ханган ажиллаж байна

### Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал

Монложистикс Холдинг ХК-ийн эрх барих дээд байгууллага бол хувьцаа эзэмшигчдийн хурал юм. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2023 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр зайнаас буюу цахим хэлбэрээр 86.59%-ийн ирцтэй хуралдаж дараах шийдвэрүүдийг гаргасан. Үүнд:

1. Монложистикс Холдинг ХК-ийн дүрмийн шинэчилсэн төслийг батлав.
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг 4 жилийн хугацаатайгаар кумулятив аргаар сонгов.
3. Компанийн 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэлх хугацааны Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны төсвийг батлав.
4. Гол ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн хүрээнд опцион гаргахыг Төлөөлөн удирдах зөвлөлд зөвшөөрөв.

### Хяналт

Компани 3 шугамын хяналтын зарчмаар үйл ажиллагаандаа бүхэлд нь хяналт тавьж ажилладаг. 1-р шугамын хяналт буюу ажилтнууд болон тэдний шууд удирдлага нь өдөр тутмын үйл ажиллагаагаа хянаж, дотоод хяналтын нэгжээс мөн хяналт тавьдаг бол 2023 онд 2 ба 3-р шугамын хяналтууд болох нийцлийн удирдлага, дотоод аудит хэрэгжиж эхэлсэн юм.



#### 1. Нийцлийн удирдлага

Монложистикс Холдинг ХК, түүний охин компаниудын үйл ажиллагаа болон дотоод хэм хэмжээний актууд нь хууль, эрх зүйн хэм хэмжээнд хянан нийцүүлэх замаар хууль эрх зүйн хэм хэмжээг зөрчсөний үр дүнд үүсэж болох эрсдэлүүдээс сэргийлэх, компанид нийцлийн соёлыг бүрдүүлж төлөвшүүлэх зорилготой.

2024 онд компани нийцлийн хяналтыг хэрэгжүүлж, үл нийцлийг залруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.


#### 2. Дотоод аудит

Дотоод аудит нь компанийн үйл ажиллагааг сайжруулах, үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хараат бус, бодитой баталгаажуулалт хийх болон зөвлөх үндсэн зорилготой бөгөөд системтэй стандарт, шалгуурт нийцсэн аргачлал ашиглаж компанийн эрсдэлийн удирдлага, хяналт, засаглалын тогтолцоог үнэлж, сайжруулах замаар компанийг зорилгодоо хүрэхэд нь туслах үүрэгтэй.

#### 3. Хөндлөнгийн аудит

Компанийн санхүүгийн тайланг аудитын олон улсын стандартад заасан арга, хэлбэрээр, хараат бусаар, мэргэжлийн байх зарчмуудыг баримтлан хөндлөнгийн аудитын Грант Торнтон ХХК ажиллаж, аудитын үйл ажиллагааг явууллаа.

### 2023 оны ТУЗ-ийн хурлын ирцийн байдал



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



**Лувсанжамба  
ГАНЗОРИГТ**

Үүсгэн байгуулагч  
ба ТУЗ-ын дарга

Санхүү, олон улсын худалдааны чиглэлээр 30 жилийн туршлагатай.



**Бааст  
ТЭЛЭНГЭД**

Үүсгэн байгуулагч, ТУЗ-ийн ердийн гишүүн

Тээвэр ложистикийн салбарт 30 жилийн туршлагатай.



**Өлзийбаяр  
ГАНЗОРИГ**

ТУЗ-ийн ердийн гишүүн

Банк, санхүү, даатгалын салбарт 22 жилийн засаглал, гүйцэтгэх удирдлагын туршлагатай.



**Ганзоригт  
ХИШИГБАТ**

ТУЗ-ийн ердийн гишүүн

Санхүү, Хөрөнгө оруулалтаар 10 жил, засаглал удирдлагын чиглэлээр 7 жилийн туршлагатай.



**Балдан  
ЭНХТҮВШИН**

ТУЗ-ийн ердийн гишүүн

Банк, санхүү, даатгалын салбарт 20 жилийн засаглал, гүйцэтгэх удирдлагын туршлагатай.



**Эрэндoo  
ОЮУНБИЛЭГ**

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Банк санхүүгийн салбарт 30 гаруй жилийн компанийн засаглалын мэргэшсэн туршлагатай.



**Санжаа  
САЙНБАТ**

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Худалдаа үйлчилгээний салбарт засаглал удирдлагын чиглэлээр 20 жилийн туршлагатай.



**Готов  
ЦЭРЭНПҮРЭВ**

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Олон улсын банк санхүүгийн салбарт 40 жилийн удирдах чиглэлийн туршлагатай.



**Сэнгээ  
ЭНХ-АМГАЛАН**

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Бизнесийн удирдлага, засаглал, гүйцэтгэх удирдлагын 22 жилийн туршлагатай.



**Цогт ДУЛАМСҮРЭН**

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга бөгөөд Нийцэл хариуцсан ажилтан

Хүний нөөц, захиргаа, эрх зүй, засаглалын 20 жилийн туршлагатай.

# ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ



Толгой компанийн бизнесийн үйл ажиллагааг Гүйцэтгэх захирал удирдан чиглүүлдэг ба Гүйцэтгэх захирлын шууд удирдлагад Санхүү, Мэдээлэл технологи, Стратеги бизнес хөгжил, Захиргаа хүний нөөц, Ложистик гэсэн 5 хэлтэс харьяалагддаг.



**Г. Хишигбат**  
Монложистикс Холдинг ХК  
Гүйцэтгэх захирал

Санхүү, Хөрөнгө оруулалтын чиглэлээр 10 жил, засаглал гүйцэтгэх удирдлагын чиглэлээр 7 жилийн туршлагатай.



**А. Одгэрэл**  
Ложистик эрхэлсэн захирал

Тээвэр ложистикийн салбарт 18 жил, засаглал, гүйцэтгэх удирдлагын чиглэлээр 7 жилийн туршлагатай.



**З. Шинэ-Од**  
Санхүү эрхэлсэн захирал

Худалдаа, үйлдвэрлэл, тээврийн салбарт санхүү менежмент чиглэлээр 12 жилийн ажлын туршлагатай.



**Э. Элдэв-Очир**  
Стратеги, бизнес хөгжил эрхэлсэн захирал

Банк, Санхүү, Хөрөнгө оруулалтын чиглэлээр 8 жилийн ажлын туршлагатай.



**Б. Азжаргал**  
Үйл ажиллагаа эрхэлсэн захирал

Олон улсын худалдаа, Хүний нөөц, засаглалын 13 жилийн ажлын туршлагатай.



**Т. Батзаяа**  
Технологи эрхэлсэн захирал

Мэдээлэл технологийн салбарт 17 жилийн технологи, гүйцэтгэх удирдлагын туршлагатай.

# ОХИН КОМПАНИУДЫН УДИРДЛАГА



**Г. Хишигбат**  
Гүйцэтгэх захирал  
Монложистикс Холдинг ХК

Санхүү, Хөрөнгө оруулалтаар 10 жил, засаглал удирдлагын чиглэлээр 7 жилийн туршлагатай.



**Б. Тэлэнгэд**  
Гүйцэтгэх захирал  
Монложистикс Транзит ХХК

Тээвэр ложистикийн салбарт 30 жилийн туршлагатай.



**Н.Алтанзул**  
Гүйцэтгэх захирал  
Монложистикс Тракинг ХХК

Тээвэр ложистикийн салбарт 18 жилийн туршлагатай.



**И.Цогбаяр**  
Гүйцэтгэх захирал  
Монложистикс Ворлдвайд ХХК

Тээвэр ложистикийн салбарт 4 жилийн туршлагатай.



**Н.Эрдэнэбилэг**  
Гүйцэтгэх захирал  
Каус Аустралис ХХК

Төмөр зам, тээвэр ложистикийн салбарт 30 жилийн туршлагатай.



**Тугаринов.В.А**  
Гүйцэтгэх захирал  
Монложистикс Транс Сервис ХХК

Төмөр зам, тээвэр ложистикийн салбарт 14 жилийн туршлагатай.

## ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Монложистикс Групп нь тулгарч болох эрсдэлүүд, тэдгээрт нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бодлого чиглэлийг боловсруулан хэрэгжүүлж охин компаниудын үйл ажиллагааг эрсдэлийн бодлоготой уялдуулан ажилладаг.

Монложистикс Холдинг ХК-ийн ТУЗ-ийн Аудит, эрсдэлийн удирдлагын хороо нь эрсдэлийн удирдлагын бодлого болон хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг бол гүйцэтгэх удирдлагын баг нь эрсдэлийн удирдлагын тогтолцоог компанийн үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлдэг. Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ дараах хяналтын процессын дагуу хийж гүйцэтгэдэг. Үүнд:

1. Эрсдэлийг тодорхойлох

2. Эрсдэлийн үнэлгээ тогтоох

3. Тайлагнах болон хариу арга хэмжээг боловсруулах

4. Эрсдэлийг бууруулах

### Тактик болон үйл ажиллагааны эрсдэл

**Компанийн хэвийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд эрсдэлийг удирдах процесс**

Тээврийн үнийн индекс, боомт, далай, төмөр замын нөхцөл байдал, валютын хэлбэлзэл, харилцагчийн сэтгэл ханамж үзүүлэлт, тээврийн менежментийн үзүүлэлт (ОТР), тээврийн сувгийн хөгжүүлэлт, хүний нөөцийн эргэц зэрэг өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн түвшинд зохион байгуулахад учирч болох эрсдэлийг тодорхойлж бууруулахад чиглэн ажилладаг.

### Бизнесийн эрсдэл

**Компанийн дунд болон урт хугацааны стратегийг хэрэгжүүлэхэд эрсдэлийг удирдах процесс**

Монгол улс болон олон улсын эдийн засгийн нөхцөл байдал, засгийн газрын бодлого, эрх зүйн орчин, геополитикийн нөхцөл байдал зэрэг нь компанийн бодлогын түвшинд хэрэгжүүлж буй төсөв төлөвлөгөөнд учирч болох эрсдэлийг тодорхойлж бууруулахад чиглэн ажилладаг.

Монложистикс Группийн үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн хувьд экспорт, импорт, транзитын тээвэр хийж гүйцэтгэж байгаа бөгөөд тэдгээр тээврүүд нь бүгд Монгол улсын хилийн боомтууд болон бусад улс орнуудын хил гаалиар дамжин тээвэрлэгддэг. Иймд ложистикийн компанид үүсэж болох хамгийн түгээмэл эрсдэлийг тодорхойлбол хил гаалийн хэвийн үйл ажиллагаа алдагдах, байгалийн давагдашгүй хүчин зүйлс тулгарах, зам дэд бүтцийн хэвийн горим алдагдах, тээвэрлэлтийн явцад ачаа бараанд гэмтэл учрах зэргээс үүдэн тээврийн маршрут өөрчлөгдөх, өртөг нэмэгдэх, тээвэрлэлтийн хугацаа уртсах зэрэг эрсдэлүүд байдаг.

<b>Гол эрсдэлүүд</b>	<b>Тулгарч болох эрсдэл</b>	<b>Авч буй арга хэмжээ</b>
Хууль эрх зүйн орчны эрсдэл	Олон улсын дүрэм журам, дотоодын хууль эрх зүйн зохицуулалт өөрчлөгдөх, түүнийг дагаж мөрдөөгүйгээс шалтгаалан үйл ажиллагааны хязгаарлалтад орох эрсдэл	Холбогдох хуулийн шинэчлэлтүүдийг судалж хамтран ажиллах гэрээг сайжруулж боловсронгуй болгох болон шинээр үүсэж болох бизнесийн боломж болон эрсдэлийг тодорхойлон бизнесийн богино хугацааны стратеги төлөвлөгөөнд тусган ажиллалаа.
Ажиллах хүчин хомстох эрсдэл	Ажиллах хүчний хомсдол үүсэж компанийн өсөлт болон хэвийн үйл ажиллагааны процесс алдагдах эрсдэл	Хүний нөөцийн бодлого, инновацыг цаг үетэй уялдуулж тогтмол сайжруулах ажлыг зохион байгуулж үйл ажиллагаанд тухай бүр нэвтрүүлж, ажилтнуудын чиг хандлага, дуу хоолойг тогтмол сонсох дотоод талбарыг дотооддоо бий болгон ажиллалаа.
Хил гаалийн хэвийн үйл ажиллагаа алдагдах	Дэлхий нийтийг хамарсан цар тахал, дайн, улс төр эдийн засгийн хямрал, геополитикийн таарамжгүй нөхцөл байдал зэрэг нь хил гаалийн хориг саадыг бий болгож, боомтын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах эрсдэл	Хамтран ажиллагч түнш байгууллагуудын холбоог өргөжүүлэн, хамтарсан шинэ тээврийн маршрутыг хөгжүүлж зах зээлд нэвтрүүлэх зэрэг ажлыг зохион байгуулж ажиллалаа.
Үнийн өрсөлдөөн бий болж үнэнч харилцагчийг алдах эрсдэл	Ажиллах хүчний хомстол үүсэж компанийн өсөлт болон хэвийн үйл ажиллагааны процесс алдагдах эрсдэл	Харилцагчийн үйлчилгээний стандартыг сайжруулах ажлын хүрээнд компанийн дотоод процессыг сайжруулах болон харилцагчийн сэтгэл ханамжийн үнэлгээг гадны байгууллагаар хийлгүүлэн өөрсдийн үйл ажиллагааг харилцагч төвтэй болгох ажлыг эхлүүлэн ажиллалаа.
Санхүүгийн хөрвөх чадвар алдагдах	Төлбөр түргэн гүйцэтгэх зохистой түвшин алдагдах, хөрвөх чадвар алдагдах, улмаар бизнесийн үйл ажиллагаанд саатал үүсэж, ашигт ажиллагаа буурах эрсдэл	Компанийн богино хугацаат авлага, өглөгийг зорилтот түвшинд төлөвлөх ажлыг тасралтгүй зохион байгуулж хямд эх үүсвэртэй зээлийн бүтээгдэхүүнийг судлан үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ашиглалаа.
Дижитал шилжилтийн эрсдэл	Дотоод ашиглаж буй программ хангамжийн хэвийн үйл ажиллагаа доголдох, мэдээллийн аюулгүй байдал алдагдах нөхцөлд бизнесийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөх эрсдэл	Системийн хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс серверийг олон улсын AWS (Amazon Web Services), GSP (Google Cloud Platform) болон дотоодын Мобиком серверт тус тус тархаан байршуулж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд дотоод ажилтнуудад сургалтыг тогтмол зохион байгуулан эрсдэлийг бууруулан ажиллалаа.

# ДОТООД АУДИТЫН ТОГТОЛЦОО

## ДОТООД АУДИТЫН БОДЛОГО

Группийн бүхий л түвшинд эрсдэлд суурилсан дотоод аудитыг дараах чиглэлээр явуулдаг. Үүнд:

- Компанийн засаглал, мөрдөгдөж буй дүрэм журам эрх зүйн баримт бичгүүдийг үнэлэх, зөвлөмж өгөх
- Дотоод хяналтын үйл явцын үр нөлөөтэй байдлыг үнэлэх, сайжруулахад дэмжлэг үзүүлэх
- Бизнес төлөвлөгөө хэрэгжихгүй байх, гадаад, дотоод орчны нөлөөллийн эрсдэлийг тодорхойлох, түүнд хариу арга хэмжээ авах үйл явцын үр нөлөөтэй байдлыг үнэлэх, зөвлөмж өгөх
- Удирдлагын тогтолцооны стандартуудын хэрэгжилтэд дотоод аудит хийх, зөвлөмж өгөх, аудитын дагуу хийсэн сайжруулалтын үр нөлөөтэй байдлыг үнэлэх

## 2023 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

- Охин компаниудад засаглал, эрсдэл, дотоод хяналтын төлөвшлийн үнэлгээ хийж, суурь төвшнийг тогтоож, холбогдох зөвлөмжөөр хангаж ажилласан.
- Охин компаниудын үйл ажиллагаанд Дотоод аудитын дунд хугацааны төлөвлөгөөнд тусгагдсан эрсдэлийн хүрээнд 12 процессын 96 алхам дээр 118 асуудал тодорхойлж холбогдох зөвлөмжийг өгсөн.
- Толгой компанийн бүх алба, нэгжүүдэд охин компаниудад “Менежментийн үйлчилгээ - үзүүлэх гэрээ”-ний шаардлагуудын дагуу аудит хийж нийт 23 зөвлөмж өгч, хэрэгжилтийн үнэлгээ хийсэн.
- 2023 онд Дотоод аудиторыг чадавхжуулах, Дотоод аудит, Эрсдэлийн удирдлагын суурь бүтцийг бий болгох, эрсдэлд суурилсан аудитын соёлыг тогтоох чиглэлээр анхаарал хандуулж ажиллаа.

## БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Дотоод аудитор нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудит, эрсдэлийн удирдлагын хорооны харьяанд ажилладаг. Аудит, эрсдэлийн удирдлагын хороо нь Дотоод аудитын дүрэм, Дотоод аудитын дунд хугацааны төлөвлөгөө, Дотоод аудитын жилийн төлөвлөгөө, нөөц, сургалтын төсвийг батлах, Дотоод аудиторыг томилж, цалин урамшууллыг тогтоохоос гадна, аудитын төлөвлөгөөний гүйцэтгэл, үйл ажиллагаанд хяналт тавьж, Дотоод аудиторын бие даасан, хараат бус байдлыг баталгаажуулдаг.





## НОГДОЛ АШГИЙН ТУХАЙ

Ногдол ашгийн бодлогын дагуу Компани нь үйл ажиллагаа болон стратегийн бодлоготой уялдсан байх ба Компанийн хувьцаа эзэмшигчид болон хөрөнгө оруулагчдын оруулсан хөрөнгийг зүй зохистой захиран зарцуулж, жил бүр ногдол ашгийн хэмжээг зохистой түвшинд хуваарилах бодлого баримталдаг.

Компани дор дурдсан нөхцөлд цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна. Үүнд:

- Ногдол ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байх
- Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүний татан буулгалтын үнэ, компанийн дүрэмд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ зэргийн нийлбэрээс их байх
- Компани нь эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх

Компанийн ТУЗ нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэнэ. Компани нь ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн бол энэ тухай хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд заавал тайлагнана. ТУЗ ногдол хуваарилах тохиолдолд Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдсанаас хойш 60-аас илүүгүй хоног байна. Ногдол ашгийн хэмжээ нь татварын дараах цэвэр ашгийн 20%-50% байна.

### 2023 ЖИЛИЙН ЭЦСИЙН ЦЭВЭР АШГААС НОГДОЛ АШИГ ХУВААРИЛНА

“Монложистикс Холдинг” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн №24/ТУЗ/06 тоот тогтоолоор компанийн 2023 оны жилийн эцсийн цэвэр ашгийн 48 /дөчин найм/ хувь буюу 3,000,609,870.76 /гурван тэрбум зургаан зуун есөн мянга найман зуун далан төгрөг далан зургаан мөнгө/ төгрөгийг нийт хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон олгохоор шийдвэрлэсэн.

Нэгж хувьцаа тус бүрд 7.58 /долоон төгрөг тавин найман мөнгө/ төгрөгөөр тооцож ногдол ашгийг хуваарилна.

Ногдол ашиг авах эрхтэй компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоон, ногдол ашгийг 2024 оны 04 дугаар сарын 30-ны өдрийн дотор “ҮЦТХТ” ХХК-иар дамжуулж олгохоо мэдэгдлээ.

# ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

MSE: **MLG**  
 Гаргасан нийт хувьцаа: **395,858,822 ширхэг**  
 2023 оны эцсийн хаалтын ханш: **180.39**  
 Зах зээлийн үнэлгээ: **71,4тэрбум.₮**

2023 оны 09 дүгээр сарын 27-ноос он дуустал хугацаанд 7,808,454 ширхэг үнэт цаас 1,427,446,489 төгрөг буюу өдөрт дунджаар 128,007 ширхэг хувьцаа 23,400,762 төгрөгөөр арилжаалагджээ. Нийт арилжааны дундаж ханш 182.8₮ байна.

Монложистикс Холдинг ХК нь 2024 оны 1-р сарын 16-ны өдрөөс Монголын хөрөнгийн бирж ХК-ийн “Үнэт цаасны үнийн индекс тооцох тухай журам”-ын дагуу ТОП-20 индексийн багцад орсон билээ.

Хувьцааны хаалтын ханш:

- Дунджаар VWAP 165.42,
- Хамгийн ихдээ 199.05 төг (2022.09.27-ны өдөр),
- Хамгийн багадаа 150.99 төг (2023.10.12-ны өдөр) байв.

## АНХДАГЧ АРИЛЖААНЫ ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Монложистикс Холдинг ХК-ийн гаргасан нийт хувьцаа: **395,858,822**  
 Олон нийтэд санал болгосон хувьцаа: **59,378,822**

Монложистикс Холдинг ХК-ийн IPO-н захиалгын үнийн дүн ₮11.3 тэрбумд хүрч 101.7%-ийн гүйцэтгэлтэй хаагдсан билээ. Улмаар нийт захиалгын дүн нь татан төвлөрүүлэх дүнгээс ₮337.8 саяар давсан байна. Нийт 1,307 хөрөнгө оруулагч анхдагч зах зээлийн арилжаанд оролцсон ба хөрөнгө оруулагчдын дундаж нас 35, хамгийн залуу хөрөнгө оруулагч 1 настай байсан байна. Өмнөд Судан улсаас “Энхийг сахиулагч цэрэг” хөрөнгө оруулалт хийсэн, БНХАУ-ын 3 хувь хүн хөрөнгө оруулсан зэрэг нь онцлог үйл явдал байв.

Стратегийн хөрөнгө оруулагчдын хувьд 2024 оны 3-р сарын 28-ны өдрөөс хувьцаагаа худалдах эрх нь нээгдлээ.



Үйл ажиллагааны жилийн тайлан 2023 он

# ӨСӨЛТИЙН ЦУВААНД ХАМТДАА



# 06

## Санхүүгийн тайлан

---

Үйл ажиллагааны жилийн тайлан 2023 он

## НЭГТГЭСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Орлогын тайлангын үзүүлэлт (сая ₮)	2021 restated	2022 restated	2023
Борлуулалтын орлого	89,479	136,095	210,361
Борлуулалтын өртөг	(80,816)	(119,548)	(192,253)
<b>Нийт ашиг</b>	<b>8,662</b>	<b>16,547</b>	<b>18,108</b>
Борлуулалт, Удирдлагын зардал	(3,411)	(6,244)	(8,482)
Бусад орлого	238	1,460	(48)
Бусад зардал	(339)	(344)	(288)
<b>Үйл ажиллагааны цэвэр ашиг</b>	<b>5,150</b>	<b>11,419</b>	<b>9,290</b>
Санхүүгийн орлого (зардал)	2	(385)	295
<b>Татварын өмнөх цэвэр ашиг (ЕВТ)</b>	<b>5,152</b>	<b>11,034</b>	<b>9,585</b>
ОАТ-н зардал	(689)	(1,642)	(1,222)
<b>Цэвэр ашиг</b>	<b>4,463</b>	<b>9,392</b>	<b>8,363</b>
Толгой компанийн хувьцаа эзэмшигчид	4,057	8,028	5,925
Хяналтын эрхгүй хувь оролцоо	406	1,364	2,438
<b>Бүх дэлгэрэнгүй орлого</b>			
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0	(138)	(62)
<b>Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого</b>	<b>4,463</b>	<b>9,253</b>	<b>8,301</b>
Толгой компанийн хувьцаа эзэмшигчид	4,058	7,890	5,863
Хяналтын эрхгүй хувь оролцоо	406	1,364	2,438
<b>Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого</b>	<b>4,463</b>	<b>9,253</b>	<b>8,301</b>
<b>Нэгж хувьцаанд ноогдох ашиг суурь ашиг (алдагдал)</b>	<b>10.25</b>	<b>20</b>	<b>15</b>

## НЭГТГЭСЭН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

Санхүү байдлын тайлангын үзүүлэлт (сая ₮)	2021 (restated)	2022 (restated)	2023
Мөнгөн хөрөнгө	5,816	14,198	22,122
Дансны авлага	13,630	19,504	22,535
Богино хугацаат хөрөнгө оруулалт	-	-	2,461
Урьдчилж төлсөн төлбөр	4,471	5,662	6,050
Бусад эргэлтийн хөрөнгө	592	361	1,409
<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>24,508</b>	<b>39,725</b>	<b>54,577</b>
Үндсэн хөрөнгө	1,216	1,449	1,526
Ашиглах эрхтэй хөрөнгө	-	-	857
Бусад эргэлтийн бус хөрөнгө	310	923	648
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>1,527</b>	<b>2,372</b>	<b>3,031</b>
<b>Нийт хөрөнгө</b>	<b>26,034</b>	<b>42,097</b>	<b>57,609</b>
Дансны өглөг	6,038	14,591	12,409
Урьдчилж орсон орлого	337	1,558	837
Богино хугацаат зээл	750	-	17
Бусад өглөг	550	597	465
<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>7,676</b>	<b>16,746</b>	<b>13,728</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>	<b>852</b>	<b>212</b>	<b>442</b>
<b>Нийт өр төлбөр</b>	<b>8,527</b>	<b>16,959</b>	<b>14,169</b>
Эздийн өмч	15,949	23,138	39,285
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдох	1,558	2,001	4,154
<b>Нийт Эздийн өмч</b>	<b>17,507</b>	<b>25,138</b>	<b>43,439</b>
<b>Нийт өр төлбөр ба Эздийн өмч</b>	<b>26,034</b>	<b>42,097</b>	<b>57,609</b>

# НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

**Мөнгөн гүйлгээний тайлангын үзүүлэлт (сая.₮)** **2021 restated** **2022 restated** **2023**

## ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ

Мөнгөн орлогын дүн	78,732	141,813	208,264
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	76,997	139,280	205,059
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	135	181	83
Буцаан авсан албан татвар	-	1	-
Татаас, санхүүжилтийн орлого	-	-	-
Бусад мөнгөн орлого	1,600	2,351	3,122
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>84,728</b>	<b>132,430</b>	<b>203,784</b>
Ажиллагчдад төлсөн	2,623	3,810	5,414
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	633	1,208	1,358
Бараа материал худалдан авахад төлсөн	379	14	53
Ашиглалтын зардалд төлсөн	101	9	134
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	72,982	111,634	186,877
Хүүний төлбөрт төлсөн	0	241	10
Татварын байгууллагад төлсөн	1,825	3,753	4,263
Даатгалын төлбөрт төлсөн	200	243	338
Бусад мөнгөн зарлага	5,985	11,518	5,339
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(5,997)</b>	<b>9,382</b>	<b>4,480</b>

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ

Мөнгөн орлогын дүн	2,513	221	1,416
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	3	1
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-	-
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-	416
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	25	155	604
Хүлээн авсан хүүний орлого	28	64	394
Хүлээн авсан ногдол ашиг	2,460	-	-

Мөнгөн зарлагын дүн	1,385	1,453	3,806
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	858	134	280
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	13	117	31
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	68	-	3,301
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	446	1,203	195
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>1,129</b>	<b>(1,232)</b>	<b>(2,390)</b>

## САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ

Мөнгөн орлогын дүн	1,500	7,156	17,420
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,500	3,012	6,431
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0	3,308	10,968
Төрөл бүрийн хандив	-	-	-
Бусад санхүүгийн мөнгөн орлого	-	835	22
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>80</b>	<b>7,648</b>	<b>11,383</b>
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	2,621	9,832
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	80	337	584
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	3,001	-
Төлсөн ногдол ашиг	-	853	190
Бусад санхүүгийн мөнгөн зарлага	-	835	778

Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,420	(492)	6,037
Валютын ханшийн зөрүү	(14)	725	(203)
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(3,462)</b>	<b>8,383</b>	<b>7,924</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>9,277</b>	<b>5,816</b>	<b>14,198</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>5,816</b>	<b>14,198</b>	<b>22,122</b>

Өмчийн өөрчлөлтийн тайлангийн үзүүлэлт (сая ₮)	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн	Хяналтын эрхгүй хувь оролцоо	Нийт дүн
<b>2022 оны 1 сарын 1-ний үлдэгдэл</b>	<b>100</b>	<b>(60)</b>	<b>-</b>	<b>(0)</b>	<b>15,909</b>	<b>15,949</b>	<b>1,558</b>	<b>17,507</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	8,028	8,028	1,364	9,392
Өмчид гарсан өөрчлөлт	6	-	-	-	0	6	0	7
Халаасны хувьцаа	-	(2,941)	-	-	-	(2,941)	-	(2,941)
Нэмж төлөгдсөн капитал	-	-	2,234	-	-	2,234	-	2,234
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-	-	(138)	-	(38)	-	(138)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	(921)	(921)
<b>2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	<b>106</b>	<b>(3,001)</b>	<b>2,234</b>	<b>(139)</b>	<b>23,937</b>	<b>23,138</b>	<b>2,001</b>	<b>25,138</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	5,925	5,925	2,438	8,363
Өмчид гарсан өөрчлөлт	12	-	-	-	-	12	-	12
Халаасны хувьцаа	-	3,001	-	-	(671)	2,330	-	2,330
Нэмж төлөгдсөн капитал	-	-	7,954	-	-	7,954	-	7,954
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-	-	(73)	-	(73)	(85)	(158)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	(200)	(200)
<b>2023 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	<b>119</b>	<b>-</b>	<b>10,188</b>	<b>(212)</b>	<b>29,191</b>	<b>39,285</b>	<b>4,154</b>	<b>43,439</b>

# ТАЙЛАГНАЛЫН ЗАРЧИМ

## ТАЙЛАГНАЛЫН НИЙЦЭЛ

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайланг Олон улсын стандартын зөвлөл (“НББОУСЗ”)–өөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (“СТОУС”), Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэн, Санхүүгийн тайлангийн Олон Улсын Стандарт 10 “Нэгтгэсэн санхүүгийн Тайлан” стандартын аргачлалыг ашиглан бэлтгэсэн.

## БҮРТГЭЛИЙН СУУРЬ

Нэгтгэсэн санхүүгийн тайланг аккруэль сууриар бэлтгэсэн ба үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ, хөрөнгө оруулалт болон тодорхой санхүүгийн хэрэглүүрүүдээс бусад зүйлсийг түүхэн өртгийн сууриар бэлтгэсэн.

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН ТОЛИЛУУЛГЫН ВАЛЮТ

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайланг үйл ажиллагааны валют буюу Монгол төгрөгөөр толилуулсан.

## ГАДААД ВАЛЮТААРХ АЖИЛ ГҮЙЛГЭЭ

Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээг бүртгэхдээ ажил гүйлгээ гарсан өдрийн Монголбанкнаас зарласан албан ханшаар төгрөгт хөрвүүлэн бүртгэдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийг тайлант хугацааны эцэст тайлагналын өдрөөр зарласан албан ханшийг ашиглан дахин хөрвүүлдэг. Мөнгөн бус зүйлсийг дахин хөрвүүлэхгүй бөгөөд бодит үнэ цэнээр бүртгэсэн мөнгөн бус зүйлсийг тухайн бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн ханшаар, түүхэн өртгөөр хэмжигдэж, гадаадвалютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар тайлагнадаг.

## ГАДААД ҮЙЛ АЖИЛЛАГАА

Гадаад валютаар санхүүгийн тайлан бэлтгэдэг охин компанийн санхүүгийн тайланг нэгтгэхдээ тухайн санхүүгийн тайланг Монгол төгрөгт хөрвүүлдэг. Тайлант үеийн орлого болон зардлыг ажил гүйлгээ гарсан өдрийн спот ханшаар, бүх хөрөнгө ба өр төлбөрийн балансын дансдыг санхүү байдлын тайлагналын өдрөөр зарласан албан ханшаар хөрвүүлэн тайлагнадаг. Хөрвүүлэлтээс үүссэн ханшийн зөрүүний олз, гарзыг эзэмшигчийн өмчийн хэсэгт гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц хэсэгт ангилан толилуулдаг.

## МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛГТАХ ХӨРӨНГӨ

Мөнгөтэй адилтгах хөрөнгөнд үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг, хөрвөх чадвар сайтай 3 хүртэлх сарын хугацаатай хөрөнгө оруулалт зэргийг хамруулдаг. Мөнгөтэй адилтгах хөрөнгийг хөрөнгө оруулалт болон бусад зорилгоос илүү богино хугацаат өр төлбөрийг барагдуулах зорилгоор эзэмшдэг.

## САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Групп нь тухайн санхүүгийн хэрэглүүрт хамаарах гэрээний оролцогч тал болсон үед санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг.

Дансны болон бусад авлага, гэрээний хөрөнгийг хялбаршуулсан аргаар үүссэн тухай бүр нь хүлээн зөвшөөрч нягтлан бодох бүртгэлд тусгадаг. Санхүүгийн өр төлбөрт зээл, дансны болон бусад өглөг, үүсмэл санхүүгийн хэрэгслүүд орох ба ажил гүйлгээг үүссэн өдрөөр хүлээн зөвшөөрч, бүртгэдэг.

## БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалыг анх олж авснаасаа хойш түүнийг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар бүртгэж харуулдаг. Үндсэн үйл ажиллагааг явуулахтай холбоотой ашиглагдах хангамжийн зүйлсийг хангамжийн материал гэх дансанд бараа материалын бүртгэлтэй адилаар ангилж бүртгэдэг.

## ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Ирээдүйд тухайн хөрөнгөөс эдийн засгийн өгөөж олж авах магадлалтай бөгөөд хөрөнгийн өртгийг үнэн зөв найдвартай хэмжих боломжтой тохиолдолд үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрдөг ба үндсэн хөрөнгийн дараа үеийн хүлээн зөвшөөрөлттэй холбоотойгоор тайлагналдаа хөрөнгийн өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон аливаа үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр тайлагнадаг.

Үндсэн үйл ажиллагаатай холбоотойгоор үүссэн бүх үндсэн хөрөнгүүдийг элэгдүүлэхдээ шулуун шугамын аргыг ашиглан хөрөнгийн элэгдүүлэх дүнг тооцсон хугацааны туршид системтэйгээр хуваарилан орлогын тайланд бүртгэдэг.

## БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Биет бус хөрөнгийн анх хүлээн зөвшөөрөхдөө тухайн хөрөнгийг олж эзэмшсэн аргаас хамааран өртгөөр нь эсхүл бодит үнэ цэнээр бүртгэдэг. Биет бус хөрөнгийг шулуун шугамын аргаар хоргодуулдаг ба хорогдлын зардал, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан өртгөөр нь үнэлэн тайлагнадаг.

## БОРЛУУЛАХ ЗОРИЛГООР ЭЗЭМШИЖ БУЙ ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ / БЭЭБЭБХ/

БЭЭБЭБХ-ийг анх хүлээн зөвшөөрснөөс хойш түүнийг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар бүртгэж харуулдаг. БЭЭБЭБХ -ийн үнэ цэнийн өсөлт, бууралтыг тайлант хугацааны ашиг/алдагдлаар хүлээн зөвшөөрнө. БЭЭБЭБХ анх хүлээн зөвшөөрөхөд СТОУС 5 стандартын дагуу тухайн хөрөнгийн дансны үнэ болон цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар үнэлэн бүртгэдэг ба тус бүлгийн хөрөнгийг элэгдүүлэхгүй.

## ТҮРЭЭС

Гэрээ нь санхүүгийн түрээс эсэх, эсвэл санхүүгийн түрээсийг агуулсан эсэхийг компани нь уг гэрээ үүссэн өдрөөр үнэлдэг. Санхүүгийн түрээс эхлэх өдрөөр санхүү байдлын тайландаа ашиглах эрхийн хөрөнгө болон түрээс өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг. Ашиглах эрхийн хөрөнгийг шулуун шугамын аргаар гэрээний нөхцөл болон тухайн хөрөнгийн ашиглах жилийн аль багаар бүртгүүлдэг. Түрээс эхлэх өдөр өр төлбөрийг тооцохдоо ирээдүйн түрээсийн төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнийг түрээсийн нуугдмал хүүний түвшинг (тодорхойлох боломжгүй бол зээлийн өсөн нэмэгдэх хүүний түвшинг) ашиглан дискаунтчлан тооцдог.

## АЖИЛЧДЫН БОГИНО ХУГАЦААНЫ ТЭТГЭМЖ

Ажилчдад олгох богино хугацааны тэтгэмж ажилчид холбогдох үйлчилгээ үзүүлсэн жилийн тайлант хугацааны эцсээс хойш 12 сарын дотор олгох тэтгэмж бөгөөд цалин урамшуулал, ээлжийн амралтын олговор, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, нийгмийн даатгалын шимтгэл болон бусад нийгмийн төлбөрүүд багтана.

## ХУВЬЦААТ КАПИТАЛ, НЭМЖ ТӨЛӨГДСӨН КАПИТАЛ

Энгийн хувьцаа нь хувьцааны нэрлэсэн үнээр илэрхийлэгдэнэ. Нэмж төлөгдсөн капиталд хувьцаат капитал гаргаснаас хүлээж авсан аливаа урамшуулал орох ба хувьцаа гаргахтай холбоотой шууд зардлыг холбогдох татвар суутгасан цэвэр дүнгээр нэмж төлөгдсөн капиталас хасдаг.

## ОРЛОГО, ЗАРДАЛ

Үндсэн үйл ажиллагаанд тулгуурлан орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгахдаа СТОУС 15-ын дагуу худалдан авагчтай байгуулсан гэрээний үүргийн гүйцэтгэлээр буюу хугацааны туршид хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгадаг. Үйлчлүүлэгчтэй гэрээгээр тохирсон дүнг борлуулалтын орлогоор хүлээн зөвшөөрөхөд гүйцэтгэлийн хувийн жинг баримтлах бол гэрээнд тусгаагүй нэмэлтээр үзүүлсэн үйлчилгээтэй холбоотой борлуулалтын орлогыг үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд нь хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Борлуулалтын өртгийг борлуулалтын орлоготой уялдуулж санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч, толилуулдаг. Борлуулалт маркетинг, ерөнхий удирдлагын зардал, бусад зардлыг нийт дүнгээр нь толилуулдаг.

## ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР

Орлогын албан татварын зардал нь тайлант жилийн татвар буюу тайлант оны эцсээр хүчинтэй болсон эсвэл хүчин төгөлдөр мөрдөгдөж буй татварын хувь хэмжээг ашиглан тооцоолсон татвар болон санхүү, татварын суурийн зөрүүнээс тооцоолсон хойшлогдсон татвараас бүрдэнэ.



# ТАЙЛБАР ТОЛЬ

<b>Монложистикс Групп эсвэл Групп</b>	Монложистикс Холдинг ХК болон түүний охин компаниудыг хамтад нь
<b>Толгой компани</b>	Монложистикс Холдинг ХК
<b>Охин компани</b>	Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалтад заасан хуулийн этгээдүүд
<b>Зэргэлдээ компани</b>	Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.15 дахь заалтад заасан хуулийн этгээдүүд
<b>Компанийн нэгдэл</b>	Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.14 дэх заалтад заасан хуулийн этгээдүүд
<b>Кумулятив арга</b>	Санал өгөх эрхийн нийт тоо таны эзэмшиж байгаа саналын энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна.
<b>Комплайнс</b>	Нийцэл
<b>OPT</b>	Тээврийн менежмент үзүүлэлт
<b>MSE</b>	Монголын Хөрөнгийн Бирж
<b>MLG</b>	Монложистикс Группийн Монголын хөрөнгийн бирж дээрх симбол
<b>VWAP</b>	Volume weighed average price / дундаж үнэ/
<b>НББОУСЗ</b>	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл
<b>СТОУС</b>	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт

<b>БЭЭБЭБХ</b>	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө
<b>ТУЗ</b>	Төлөөлөн удирдах зөвлөл
<b>ХЭХ</b>	Хувьцаа эзэмшигчдийн хурал
<b>ХХК</b>	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
<b>ХК</b>	Хувьцаат компани
<b>БНХАУ</b>	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
<b>ОХУ</b>	Оросын Холбооны Улс
<b>IPO</b>	Нийтэд анх удаа хувьцаа санал болгох
<b>ROE</b>	Өөрийн хөрөнгийн өгөөж
<b>ESG</b>	Байгаль орчин, Нийгэм, Засаглал 3 үгийн товчлол
<b>ААНОАТ</b>	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
<b>ISO</b>	Олон улсын стандартчиллын байгууллага
<b>CNA</b>	Сингапур улсын мэдээний суваг
<b>ПР</b>	Олон нийтийн харилцаа
<b>LMS</b>	Ложистикс менежмент систем
<b>APAC</b>	Asia Pacific
<b>EU</b>	Europe
<b>LATAM</b>	Latin America

<b>MEA</b>	Middle East & Africa
<b>NA</b>	North America
<b>ХОМК</b>	Хөрөнгө оруулалт менежментийн компани
<b>СЭЗИС</b>	Санхүү эдийн засгийн их сургууль
<b>ESOP</b>	Employee Stock Ownership Plan

# ТАЙЛБАР ТОЛЬ

<b>Тохируулах бичилт</b>	Группийн аж ахуй нэгж хооронд хийгдсэн гүйлгээ, үлдэгдлийг устгах бичилт	Нийт ашгийн хувь	=	$\frac{\text{Нийт ашиг} * 100}{\text{Борлуулалтын орлого}}$
<b>Restated</b>	Дахин тайлагнасан санхүүгийн тайлан	Цэвэр ашгийн хувь	=	$\frac{\text{Цэвэр ашиг} * 100}{\text{Борлуулалтын орлого}}$
		Өөрийн хөрөнгийн өгөөж	=	$\frac{\text{Тайлант үеийн ашиг}}{\text{Эздийн өмч}}$
		Өөрийн хөрөнгийн харьцаа	=	$\frac{\text{Монложистикс группийн эздийн өмч}}{\text{Нийт хөрөнгө}}$
		Үйл ажиллагааны эргэц	=	$\left( \frac{360}{\text{Худалдан авалт}} \times \frac{\text{Дундаж бараа}}{\text{материал}} \right) + \left( \frac{360}{\text{Авлага}} \times \frac{\text{Дундаж}}{\text{авлага}} \right)$
		Эргэлтийн харьцаа	=	$\frac{\text{Эргэлтийн хөрөнгө}}{\text{Богино хугацаант өр төлбөр}}$
		Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа	=	$\frac{\text{Эргэлтийн хөрөнгө} - \text{Бараа материал}}{\text{Богино хугацаант өр төлбөр}}$
		Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг	=	$\frac{\text{Монложистикс ногдох тайлант үеийн ашиг}}{\text{Хувьцаа тоо ширхэг}}$



**ХАЯГ**

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
1-р хороо, Нью хоризонс оффис, 11 давхар, 1101 тоот

**ХОЛБОО БАРИХ**

+976 7701-5454

[info@mlholding.mn](mailto:info@mlholding.mn)

[www.mlholding.mn](http://www.mlholding.mn)